Хол харж, ойр гишгэж яв

Ц.Лооххууз

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2017.11.21, МЯГМАР ~ №222 (768) ~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~ ҮНЭ: 1000₮

“Эх орны хишиг”-ийн зарим хувилбар

Кувейтын жишгээр явбал ямар бол гэх бодол надад төрсөн, судалж үзэхэд илүүдэхгүй. > 4

Хиймэл оюун ухаан хаяанд ирлээ

Ажилгүйдэл нь роботуудын авчирч буй асуултын тэмдэг. > 12

FT FINANCIAL TIMES

- Брюссель валютын арилжааны луйвартай тэмцлээ
- Чилийн сонгуульд тэрбумтан Пинера тэргүүлэв

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

“Засгийн газрын мэдээ” сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын тавдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Xopom.com
- Ikon.mn
- Caak.mn
- Ubinfo.mn
- Zaluu.com
- News.mn
- Medee.mn
- Zindaa.mn
- View.mn

Эх сурвалж: Alexa.com©

ОНЦЛОХ

УЛС ТӨР

УИХ-ын гишүүн асан Г.Уянга Ерөнхийлөгч Х.Баттулгад зөвлөнө.

УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, Л.Болд нар Тусгай хяналтын дэд хороонд багтлаа.

Гэр хороолол хөгжлийн намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзав.

О.Баасанхүү гишүүнийг МАХН-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхгүй гэв.

УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Ё.Баатарбилэг нар Ерөнхий сайдад асуулга тавилаа.

ЭДИЙН ЗАСАГ

Хөрөнгийн биржийн "MSE ALL" индекс 1.982.19 нэгж болж, 1.13 хувиар өсөв.

Улсын хэмжээнд нийт хадгаламж, зээлийн 291 хоршоо үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулагч байгууллагууд мэдээллийн технологид суурилсан үйлчилгээг онцлов.

Монголбанк алт худалдан авалтынхаа хэмжээг 20 тоннд хүргэхээр зорьж байна.

Мөнгөний нийлүүлэлт 1.5 хувиар буурч, 14.5 их наяд төгрөг болов.

НИЙГЭМ

Энэ онд 22800 өрхийн 9.8 сая мал отроор өвөлжиж, хаваржина.

НҮБ Монгол Улсыг хүүхдийн эрхийн тухай шийдвэрээсээ ухрахгүй байхыг зөвлөлөө.

Нийслэлийн 2018 оны төсвийн төслийг иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүллээ.

Сэлэнгэ аймгийн Мандал суманд хорио цээрийн дэглэм тогтоолоо.

“Эрчим хүчний хэмнэлттэй загвар байшин” төсөл хэрэгжлээ.

ДЭЛХИЙ

Зимбабвейн Ерөнхийлөгч 93 настай Р.Мугабе огцрох хэлэлцээ хийж эхэллээ.

Японд байрладаг АНУ-ын цэргийн албан хаагчдад архи уухыг хоригложээ.

Брекситээс хойш Британид амьдралын чанар доошилсныг судалгаа харуулав.

ОХУ-д хугацаа дууссан эмүүдийг буцаан авах цэгүүд байгуулсан байна.

Америкийн эрдэмтэд гэрийн ажил нас уртасгадагийг тогтоожээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.11.21

-13° | -18°

БАГА ЗЭРГИЙН ЦАСТАЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Уул уурхай зөвхөн эрчүүдийн салбар биш



Хөдөлмөрийн зах зээл нь хүртэл түүхий эдийн үнэд ихээхэн мэдрэг байдаг эрдэс баялгийн салбарын ажиллах хүчний 10 орчим хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг. Тиймээс салбарын үр өгөөж, хүртээмжийг нь хүйсийн ялгаварлалгүй тэлэх бодлого боловсруулах хэрэгтэй болох нь. ▶7

С.Батсайхан / ЗГМ©

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ”-гээр оюуны цангаагаа тайлдаг

Д.Батжаргал
СЭЗИС-ийн ректор

“Засгийн газрын мэдээ” сонин нь өдөр тутмын сонинуудаа манлайлж, хошуучлан бизнес эдийн засаг, санхүүгийн чиглэлийн уншуууртай, шилдэг нийтлэл, мэдээллийг хүргэдэг болохоор би өглөө болгон уншдаг юм. Эдийн засаг, банк санхүүгийн мэргэжилтнүүд төдийгүй эрдэмтэд энэ сониныг уншиж, оюуны цангаагаа тайлдаг болсондоо талархдаг. Чөлөөт хэвлэлийн зах зээлд суурьшаад гурван жил болохдоо тэргүүн эгнээнд цойлж, 2015 оны “Монголын шилдэг сонин”-оор шалгарсан нь үндэсний, өдөр тутмын шилдэг хэвлэл мөн болохыг баталсан хэрэг юм. Мөн дэлхийн шилдгийн шилдэг Financial Times сониныг Монголын уншигчдад эх хэлээрээ байнга хүргэдэгт нь талархахаас аргагүй. Түүнчлэн технологийн дэвшлийг уламжлалт үйл ажиллагаатай хослуулан нэвтрүүлж, олон мянган уншигчдад цахим сонин хүргэж байгаа нь сайшаалтай. Чөлөөт хэвлэлийн шанг татаж, үзэг нэгтнүүдээ түүчээлэн, үнэний эрэлд тууштай яваа “Засгийн газрын мэдээ” сонины хамт олонд ойн баярын мэнд хүргэе.

УЛС ТӨР

Маргаан хагалах талбар

Б.Даваатогтох
@datoZGM

Өчигдөр эхэлсэн эрх баригч хүчин болох МАН-ын XXVIII Их хурал олон нийтийн анхаарлыг туйлын их татаж байгаа юм. Үндсэн хуулиар төрийн эрхийг барих дээд байгууллага нь Улсын Их Хурал хэмээн заасан боловч үнэн хэрэгтээ улс төрийн нам болоод удаж буй. Учир нь улс орны нийгэм, эдийн засгийн чухал шийдвэрийг төрийн эрх барьж буй улс төрийн хүчин хэлэлцэж, шийдэж ирсэнтэй холбоотой.

Өнгөрсөн дөрвөн жилийн алдаа оноо, амжилтаа дэнслэхээр цугласан тус намын 1309 төлөөлөгч Соёлын төв өргөөнд хуралдаж, намынхаа бодлого, чиглэлийг шүүн хэлэлцэв. Хурлын эхэнд тус намын дарга М.Энхболд улс төрийн илтгэл тавьж, амжилт, алдаа оноо бүхнийг хуваалцах ёстой хүний нэг гэдгээ онцоллоо.

▶2

ЗГМ: ИНФОГРАФИК

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Хөгшин сэтгэхүйтэй залуу Монгол

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Хүний хөгшрөлт, өтлөлт 75-80 насанд эхэлдэг гэх сүүлийн үеийн судалгаа байна. Энэхүү судалгаагаар бол хижээл нас 50-тайд эхэлж, бараг 30 жил үргэлжилдэг аж. Энэ насныхан бие махбодь, оюун санааны хувьд буурдаггүй, харин ч тогтвортой байдаг гэнэ. Хүн амын дундаж наслалт жил ирэх тусам нэмэгдсээр байгаа нь үүнд нөлөөлжээ. Өмнө нь 50 хүрсэн хүнийг өтөл, хөгшин, ажлын чадваргүй гэж үздэг байсан бол өдгөө энэ байдал өөрчлөгдөх тал руу хэдийнэ хэлбийсэн. Харин ч хөгшин гэгдэж байсан 50 наснаас хойш үр бүтээлтэй 25 жил дахин үргэлжилнэ гэж бодохоор сайхан.

Гэхдээ дэлхий нийтийн шинэ чиг хандлага Монголд харин ч эсрэгээрээ. 30 гарч, 40 хэвийсэн бол хөгшчүүдийн эгнээнд шилжих нь холгүйд хүрэх бол 50 хүрсэн нь “асар” хөгшиндөө тооцогдоод явчихна. “Далаад оныхон амьд юм уу”, “Жараад оны динозаврууд” гэх сошиалаар явж байдаг постууд хошин марзагнал мэт боловч үнэхээр ийм бодол хүмүүст бага багаар суусаар байгааг та бид анзаарсан болов уу. Нэг ёсондоо цахим сүлжээний давалгаа хүчээ авснаас болоод нийгэм тэр чигээрээ сэтгэл санааны хөгшрөлтөд ороод байх шиг.

▶3

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1192.19 1.13%	1291.90 0.18%	6777 0.59%	98.55 0.00%	100.23 0.00%	2445.66	368.69	41.21

Улс төр

НАМУУД

Маргаан хагалах талбар

Хувийн архиваас©

Хайнааг хагалж чадвал засаг тогт-вортой ажиллах нөхцөл бүрдэнэ

◀1

Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд намаа ялалт байгуулах хэмжээнд удирдан ажиллаж чадаагүй, өөрөө нэр дэвшсэн ч годройтсон тул намын даргын хувьд улс төрийн хариуцлага хүлээх ёстой гэж улс төрийн илтгэлдээ дурдав. Гэхдээ “Ерөнхийлөгчийн сонгуулийг тойрсон улс төрийн увайгүй хэрэг явдлын уршгаар манай намд үл ойлголцол, талцлын жавар тачигнаж эхэлснийг нуух хэрэггүй. Засгийн газрыг огцруулах асуудал намын бүлэг, Удирдах зөвлөл, Бага хурал, Их хурал гээд шат шатны байгууллагаараа дамжиж, асуудал өрнөсөн бол хэнийг ч буруутгах аргагүй. Хуваагдал талцал үүсэхгүй, манай нам нийгэмд муухай харагдахгүй байх байлаа” хэмээн шүүмжлэлтэй, бас харамсангүй хандлаа.

Их хурлын эхний өдөр намын дүрмийн шинэчлэлээ хэлэлцэв. Хаалттай хуралдаанаар хэлэлцсэн дүрмийн шинэчлэлийн хүрээнд хэд хэдэн өөрчлөлт оруулахаа намын дүрэмд өөрчлөлт оруулах Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд онцлов. Тэрбээр “Найман чиглэлээр 50 гаруй зүйл, заалтыг өөрчилж байгаа. Нэгдүгээрт, шийдвэр гаргах түвшинд намынхаа анхан шатны гишүүдийг оролцуулдаг байх зохицуулалт хийнэ. Хоёрдугаарт, Удирдах зөвлөл болон Хяналтын хорооны гишүүдийн тоог багасгана. Тухайлбал, Удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 29 хүртэл гэж оруулсан. Гуравдугаарт, хариуцлагатай, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлэх чиглэл тусгасан. Улс төрийн намын санхүүжилт хаалттай байна. Үүнийг дагаад авлига хээл хахууль авдаг гэж яригддаг. Өнөөдөр МАН-ын санхүүжилтийн үйл ажиллагааг журамд оруулж, тэрхүү журмыг Бага хурлаар баталснаар намын санхүүжилт ил тод нээлттэй болох нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн намын гишүүдийн ёс зүйтэй холбоотой шинэ бүтцийг шинээр оруулж ирлээ” гэв. Мөн Удирдах зөвлөлийг намын Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах зохицуулалтыг шинээр оруулж өгчээ.

Анхаарал татаж буй нэг асуудал нь Ёс зүйн хороо

Тус намын гишүүд, ялангуяа УИХ-ын нэр бүхий зарим гишүүний тарьсан хэл амнаас үүдэн хамгийн их анхаарал татаж буй нэг асуудал нь Ёс зүйн хороо юм. Өнгөрсөн XXVII Их хурлаас Хяналтын хороонд дээрх чиг үүргийг шилжүүлсэн ч энэ удаад бие даасан бүтэц байгуулахаар зорьжээ. Ингэхээс ч аргагүй хэмжээнд хүртэл тус намын зарим нөхөд цадигаа алдсан юм. Энэ талаар тус намын дарга М.Энхболд “Төрийн болон намын өндөр албан тушаалд очиж буй хүмүүстэй ажил хэргийн хийгээд ёс зүйн хариуцлагын гэрээ байгуулдаг, буруу зүйл хийсэн нь тогтоогдсон бол хатуу хариуцлага тооцдог болох, буруугаа хүлээдэг, олон нийтээс уучлалт гуйдаг ёс зүйг хэвшүүлэхэд чиглэсэн дүрмийн маш нарийн, хатуу зохицуулалтыг хуульд нийцүүлэн хийх ёстой” гэлээ.

Дашрамд дурдахад, өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулиас хойш тус намд үүссэн талцал хуваагдал, маргаан мэтгэлцээнийг хагалах талбар нь энэ удаагийн XXVIII Их хурал байх учиртай. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа тус намд өрнөсөн дотоод “зодоон” Засгийн газраа огцруулахад хүргэж, эцэстээ намын даргын сунгаагаар ийнхүү үргэлжилж байна. МАН-ын дарга хэн болохоос хамаарч улс төр хийгээд улс орны ирэх хоёр жил буюу 2020 оны сонгууль хүртэлх үйл явцыг урьдчилсан байдлаар зураглаж болох юм. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын тогтвортой байдал ч намын эрх мэдлийн хуваарилалт хэний гарт шилжихээс хамаарч буй. УИХ дахь 65-ын бүлэгт албан бусаар байгуулагдсан 32, 33-ын бүлгийн хайнааг энэ удаагийн Их хурлаар хагалж чадвал төр засаг цаашид тогтвортой ажиллах нөхцөл бүрдэх юм хэмээн найдаж буй.

МАН төрийн эрхийг барьж буй бол МАН-ын эрхийг хэн барих эсэх асуултын хариу өнөөдөр эцсийн байдлаар тодорно. Урьдчилсан байдлаар Ерөнхий сайд У.Хүрэлсүх, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа, тус намын гишүүн Н.Дэмбэрэл, Г.Майцэцэг нар намын даргад өрсөлдөхөө мэдэгдээд байгаа. Их хурлын 1309 төлөөлөгчийн хамгийн олон санал авч чадсан нь эрхэм намын даргаар сонгогдож, гишүүдийнхээ итгэлийг өвөрлөн Монгол Улсын төлөө ханцуй шамлан ажиллах учиртай. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ

МАН-ын даргаар ямар хүн сонгогдох ёстой вэ?

УИХ-ын гишүүн Я.Содбаатар: Намын даргын тухайд хувь хүн гэхээс илүү баримтлах бодлогоор нь дүгнэх ёстой. МАН Засгийн эрхийг барьж буй учир сонгодог парламентад байдаг жишгээр Ерөнхий сайд нь намын даргаа давхар хаших нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Бид засаглалын эрхийг өгсөн. Одоо улс төрийн эрхийг нь өгвөл хоёр далавч нь зэрэг дэвж байж илүү хүчирхэг байх юм.

УИХ-ын гишүүн Д.Оюунхорол: Энэ Их хурлаар намын даргыг шинээр сонгох байх. Хүрэлцэн ирсэн төлөөлөгчид намынхаа эв нэгдэл, үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх чадвартай дарга сонгоно гэдэгт итгэлтэй байна. Одоогоор нэр дэвшигч тодорхой болоогүй. Намын Их хурлын зааланд нэр дэвшигчид тодорно. Намын үнэт зүйл бол боловсон хүчний бодлого байдаг. Улс төрийн нам бэхжиж, төлөвшихийн тулд боловсон хүчний бодлогоо шатлан дэвших зарчмаар явуулах шаардлагатай. Их хуралд хүрэлцэн ирсэн 1309 төлөөлөгч ч мөн адил ийм хүлээлттэй байгаа байх.

УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат: Асуудлыг тойроод, илээд өнгөрөлгүй, голыг нь барьж аваад, шийдэлд хүрээсэй гэж хүсч байна. МАН удирдлагын түвшинд бол хоёр тийш харсан уур амьсгалтай байгаа. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг эвлэрүүлж чадах чадвартай хүн сонгогдоосой гэж бодож байна. Ямар ч улс төрийн нам гэдэг нь хувь хүний компани биш. Тушаалаар хөдөлдөг цэргийн байгууллага биш. Нам бол мянга, мянган хүмүүсийн итгэл үнэмшил, үнэт зүйл дээр оршин тогтдог. Тиймээс эв нэгдлийг хангаж чадах хүн МАН-ын дарга болоосой.

Нийслэлийн Засаг дарга С.Батболд: Их хуралд би тав дахь удаагаа оролцож байна. Энэ хурал эв найрамдлын хурал болох учиртай. Хурлаар намд тулгамдаж буй асуудал, шинэчлэлийн зорилтуудыг ярилцдаг. Хоёрдугаарт, эрх баригч нам дараагийн жилүүдэд ямар бодлого барих, улс орны хөгжлийн бодлогыг ярилцдаг. Бидэнд нийгэм, эдийн засаг, санхүүгийн шийдвэрлэх асуудал их байна. 2020 онд ялалт байгуулахын тулд, ард түмэнд амласан амлалтаа биелүүлэхийн төлөө тогтвортой байдал эв нэгдлийг хангах нь өнөөдрийн хөндөгдөх гол сэдэв байх болно.

НИТХ-ын дарга С.Амарсайхан: Намын шинэ дарга гишүүд дэмжигчдийнхээ оролцоог бий болгох замаар улс орныхоо хөгжлийн бодлогыг зөв тодорхойлж тогтвортой үйл ажиллагаа явуулахад анхаарах ёстой. Эрх барьж буй намын дарга гэдэг бол улс орны ирээдүйн хөгжлийн бодлогыг яаж тодорхойлж, ямар цаг хугацаанд, хэрхэн үр дүнтэй зохион байгуулах вэ гэдгийг хамгийн нэгдүгээрт тавьж явах ёстой хүн. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТОМИЛГОО
УИХ-ын гишүүн асан Г.Уянга Ерөнхийлөгчийн Иргэний эрхийн асуудал хариуцсан зөвлөхөөр томилогджээ. Ерөнхийлөгчийн шийдвэрээр өнгөрсөн долоо хоногт тэрбээр дээрх албан тушаалд томилогдсон байна.

» ЗАСГИЙН ГАЗАР
УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Ё.Баатарбилэг нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Шинжлэх ухааны академийн төсөв, хөрөнгө оруулалт, төрийн захиалгат судалгаа, шинжилгээний ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ”-ний талаар асуулга тавьсан. Тэгвэл энэ талаарх мэдээллийг Ерөнхий сайд У.Хүрэлсүх ирэх баасан гарагт өгөхөөр болжээ.

» НАМУУД
УИХ-ын гишүүн О.Баасанхүүг намын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхгүй гэж МАХН-ын Гүйцэтгэх товчооноос мэдээллээ. Учир нь О.Баасанхүү гишүүн намын дүрмийг мөрддөггүй, МАХН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн эсрэг ажилласан зэрэг шалтгаануудыг нэрлэж байлаа.

» ШИЙДВЭР
Гэр хороолол хөгжлийн намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай Б.Батсүх нарын хүсэлтийг Улсын дээд шүүх өчигдөр хянан хэлэлцлээ. Хүсэлтэд хавсаргасан баримт нь Улс төрийн намын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж үзэж, Дээд шүүх уг намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан байна.

» ДЭД ХОРОО
УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, Л.Болд нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүн болгох шийдвэрийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргажээ. Тус дэд хорооны гишүүдийн томилготой холбоотойгоор АН-ын бүлэг нэг хоногийн завсарлага аваад байсан юм. Тэгвэл тус бүлгийн саналаар дэд хорооны гишүүдийн тоог нэмж, дээрх хоёр гишүүнийг бүрэлдэхүүнд нь оруулжээ.

» ТОО

82

Хувь. Малчдын өвс, тэжээлийн бэлтгэл, аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ, хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтээр дүгнэхэд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 82 хувьтай гарч гарсныг салбарын яам мэдээлэв. Энэ жил хонин толгойд шилжүүлснээр 106.9 сая толгой мал өвөлжих бөгөөд 22800 өрхийн 9.8 сая мал отроор өвөлжиж, хаваржих аж.

» ХАРИЛЦАА
Хууль сахиулах салбарын алба хаагчдын чадавхийг бэхжүүлэх, багш, мэргэжилтэн урьж ажиллуулах талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Израйлиас Монгол Улсад суух Элчин сайдад санал тавьжээ. Мөн энэ үеэр хоёр орны төлөөлөгчдийг ойрын хугацаанд харилцан айлчлуулахаар тохиролцсон байна.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› INFO@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

БҮЛЭГ

Б.Хурцын талаар нийтийн сонсгол хийнэ

Б.Сэлэнгэ
ЗГМ

УИХ-ын гишүүн Ж.Батзандан “ТЕГ-ын дарга асан Б.Хурц намайг ална хэмээн заналхийлсэн тул төрийн хамгаалалт гаргаж өгнө үү” хэмээн УИХ-ын дарга М.Энхболдод хандаад буй. Түүний хэлсээр Б.Хурц нь УИХ-ын гишүүн Ж.Батзанданд хандан “Аятайхан байгаарай, үгүй бол орон дотор чинь хүнээр хорлуулж, алж чадна шүү" хэмээн хэлсэн аж. УИХ дахь Ардчилсан намын дарга Д.Эрдэнэбатын өрөөнд болсон болсон гэх уг үйл явдлыг бүлгийн даргаас гадна Л.Болд гишүүн гэрчилнэ хэмээн УИХ-ын гишүүн Ж.Батзандан мэдэгдсэн ч тэдгээрийн хэн нь ч батлаагүй юм.

Тэгвэл Ардчилсан намын бүлгийн өчигдрийн хуралдаанаар Б.Хурцын талаар нээлттэй сонсгол явуулах эсэх талаар хэлэлцэн дэмжжээ. Нийтийн сонсголын тухай хуулийн 10.10.1-т “УИХ-аас албан тушаалтныг томилохтой холбогдуулан УИХ-ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй гишүүд хүсэлт гаргасан бол томилгооны сонсголыг явуулна” гэсэн заалт бий. Тэгэхээр Ж.Батзандан гишүүний гарын үсгээр нь цуглуулсан гишүүд дээр Ардчилсан намын бүлгийн ес нэмэгдэж, нийтийн сонсгол хийх нөхцөл бүрдэж байгаа юм. Гэхдээ нийтийн сонсголыг хаалттай хийх магадлалтай гэж эх сурвалж хэлж байна. [ЗГМ]

TransBank
ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК

Зорилго тэмүүлэлтэй, бүтээлч, мэргэжлийн өндөр ёс суртахуунтай горилогчийг

АЖИЛД УРЬЖ БАЙНА

Материалыг 2017.12.11 - нийг дуустал хүлээн авна

✔ ГАДААД ХАРИЛЦААНЫ МЭРГЭЖИЛТЭН
✔ САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ
✔ МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

Яагаад ТрансБанкийг сонгох ёстой вэ?

Шинэ хөрөнгө оруулагч
Шинэ Гүйцэтгэх удирдлагын баг
Шинэ бодлого, чиглэл

Тогтвортой ажлын байр
Өсөн дэвших боломж

Дэлгэрэнгүй мэдээллийг
http://transbank.mn/careers

Утас: 7716-9999
И-мэйл: hr@transbank.mn

Нийтлэлчийн булан

Хөгшин сэтгэхүйтэй залуу Монгол

40 хүрсэн нэгнийгээ хөгшнөөр дуудах нь юуных вэ

◄1

Эм зүйн ухааны доктор Л.Хүрэлбаатар “Амжилтад хүрэх жор” номондоо “Уран зургийн үзэсгэлэн сонирхож явтал “Ямар гоё зурдаг юм бэ. Зураг зурмаар санагдчихлаа. Уг нь намайг зурах авьяастай гэж дунд сургуулийн багш маань хэлж байж билээ. Даанч одоо зурж сурна гэхээр оройтож дээ” хэмээн гуч орчим насны залуу хэлэхийг сонсоод өмнөөс нь ичив. Монголчуудын сайн мэдэх алдарт зохиолч Рабинтранат Таагүр 70 настайгаасаа зурж эхэлсэн, одоо түүнийг Энэтхэгийн орчин үеийн зургийг үндэслэгч гэж хэлэлтэй биш” хэмээн бичжээ.

С.Цогтбаяр / ЗГМ©

Бид ид хийж бүтээх насан дээр яваа нэгнээ хөгшнөөр нь дуудаж, өнөөх нь ч тийм сэтгэхүй суудаг болчихож.

Өөрийгөө хөгшин гэж гололгүй хичээн зүтгэсээр амжилтад хүрсэн энэ мэт жишээ дурдвал маш олон. Тухайлбал, АНУ-ын 40 дэх Ерөнхийлөгч Р.Рейган 55 хүртлээ том, жижиг нэг ч сонгуульд ялалт байгуулж үзээгүй. Шантарвал шантрахаар байсан хэдий ч бууж өгөөгүй. Үр дүнд нь дэлхийн хамгийн хүчирхэг гүрний жолоог найман жилийн турш атгасан юм. Түүнчлэн цагтаа “Форбес” сэтгүүлээс гаргадаг дэлхийн хамгийн баян эрхмийн жагсаалтыг хоёронтаа (1991, 1992) тэргүүлж байсан Таикихиро Мори үл хөдлөхийн бизнесээ 55 настайдаа эхлүүлсэн бол Страдивари 60-тайдаа анхны хийлээ урлаж эхэлсэн гэдэг. Гэтэл бид 40 хүрсэн нэгнийгээ хөгшнөөр нь дуудаж, 50 хүрэхээр нь бурхны орон руу илгээчих гээд байдаг нь юуных вэ.

- **Өөрийгөө хөгшин гэж гололгүй хичээн зүтгэсээр амжилтад хүрсэн жишээ маш олон.**
- **АНУ-ын 40 дэх Ерөнхийлөгч Р.Рейган 55 хүртлээ том, жижиг нэг ч сонгуульд ялалт байгуулж үзээгүй.**
- **Сэтгэлгээний хөгшрилтөд эрт ороод байвал бид Японоос ч хөгшин хүн амтай улс болсноос ялгаа юун.**

Зарим нэг тоо баримтад анхаарлаа хандуулъя. Хамгийн сүүлийн судалгаагаар Японы 65-аас дээш насны хүн амын гуравны хоёр нь ажил эрхлэхийг хүсдэг гэсэн дүн байна. Тус улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын судалгаагаар энэ оны эхний улиралд Японы 55-64 настай иргэдийн 72.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа аж. 2016 оны байдлаар арлын орны 65-аас дээш насны хөдөлмөр эрхлэгчдийн тоо 7.3 саяд хүрээд байгаа юм.

Японы энэхүү судалгааг Монголтой харьцуулахад тэнгэр газар шиг ялгаа харагдана. Тухайлбал, 2006-2016 оны хооронд манай улсын 60-64 настай иргэдийн 21.8 хувь нь л ажил эрхэлж байв. Харин 70-аас дээш насныхны хувьд энэ тоо 6.2 хувь болж үлэмж буурчээ.

Үүнийг бичихдээ тэтгэврийн насыг нэмээд өг гэж хэлэх гэсэнгүй. Угаас Япontой харьцуулахад дундаж наслалт эрс тэс зөрүүтэй болохоор хөгжилтэй орны жишгийг дагаж тэтгэврийн нас нэмэх санаа олны дэмжлэг хүлээхгүй. Харин яагаа ч үгүй байж хөгшчүүдийн эгнээнд шилжихдэг, өөрийгөө хөгшин гээд боддог, нийгмээрээ тийм ойлголттой болсныг нь эсэргүүцээд байгаа юм. Хуульд зааснаар бол хүн тэтгэвэрт гарсан хойноо ч хөдөлмөр эрхэлж болно. Гэхдээ ихэнх хүн тэтгэврийн хэдээ аваад гэрийн мухар сахихыг илүүд үздэг нийтлэг дүр төрх Монголд бат суурьшчээ. Ажил хийе ч гэсэн олддоггүй нь бидний хамгийн том гачлан.

“Сэтгэл судлалын онолоор бол хүний хийж бүтээх насыг 19-25, 26-64, 64-өөс хойших гэж гурав хуваадаг. 26-64 насанд хүн нэг бол маш их бүтээмжтэй байж амжилтад хүрдэг. Би үүнийг хийж чадах юм байна гэж өөрийгөө мэдэрдэг гэсэн үг. Харин нөгөө хэсэг нь зогсонги байдлын зөрчил буюу юу ч хийсэн бүтэхгүй байна, би чадахгүй юм байна гэж сэтгэл санаагаар унасаар байгаад дуусдаг.

Хэрэв энэ насан дээр ажилдаа сайн хандаад, хийж байгаа зүйлээсээ урам авч, өөрийгөө олон талаар хөгжүүлж чадаж байвал тэр хүн бүтээмжтэй гэсэн үг. Харин чадахгүй бол зогсонги байдлын зөрчилд ордог. 64 наснаас хойш өөрийн амьдралдаа сэтгэл ханамжтай байх эсэх нь энэ үеэс маш их шалтгаална. Сэтгэл ханамжгүй бол энэ амьдрал утга учиргүй өнгөрлөө гэх зэргээр өөрийгөө үгүйсгэж эхэлдэг.

Хүн өөрийгөө хэрхэн үнэлэхээс тухайн хүний хөгшин, залуу эсэх нь шалтгаалдаг

Мэдээж сэтгэл санааны өөрчлөлтөд нийгэм болон эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлнө. Гэхдээ хамгийн гол нь тухайн хүн өөрийгөө юу гэж үнэлдэг, тэр үнэлэмж хэр зөв бэ гэдгээс их зүйл хамаарна гэдгийг ойлгох хэрэгтэй” хэмээн Сэтгэл судлалын үндэсний төвийн сэтгэлзүйч Д.Лхамсүрэн хэлсэн юм.

Түүний хэлснээс үзвэл хүн өөрийгөө хэрхэн үнэлэхээс тухайн хүний хөгшин, залуу эсэх нь шалтгаалах нь. “Хүн хөгширсөн гэж бодсон үедээ хөгширдөг” гэсэн үг үүний илэрхийлэл. Гэтэл бид ид хийж бүтээх насан дээр яваа нэгнээ хөгшнөөр нь дуудаж, өнөөх нь ч тийм сэтгэхүй суудаг болчихож. Уг нь Япон зэрэг оронтой харьцуулахад Монголын хүн амын ихэнх нь залуус. Тодруулбал, нийт хүн амын 57.8 хувь нь 15-69 насных, 39 хувь нь 15 хүртэлх насных бол 70-аас дээш настнууд нийт хүн амын 3.6 хувийг л эзэлж байгаа юм. Эндээс харвал ид хийж бүтээх насны залуу үе Монголоор дүүрэн байна. Гэхдээ сэтгэлгээний хөгшрилтөд эрт ороод байвал бид Японоос ч хөгшин хүн амтай улс болсноос ялгаа юун. [ЗГМ]

Эрсдэлийг нь дутуу үнэлж болохгүй аюул

Цахим халдлагын 70-90 хувь нь дотоод хүчин зүйлээс шалтгаалдаг

Ц.Даян
ЗГМ

-Гүй ээ, энэ чинь юу вэ!

-Яав аа? Аваач ээ хөөе!

-Ээ, золиг гэж! Энэ чинь хулгана байна. Яагаад орчих нь энэ вэ?

-Аваач ээ, аваач! Яагаа вэ, нөгөө авдрын ангархайгаар орчихгүй юу. Чамайг эртээд хадаж өг гэж хэлээгүй юу. Одоо хамаг юм сүйтгэж гүйцнэ дээ.

-Гүй ээ, энэ чинь. Юу болох нь энэ вэ?

-Ээ бүү үзэгд! Юу ч үгүй болгочих оо шив дээ!

-Ээ, халаг минь дээ! 20 шарыг минь хоёр, гуравхан хулгана идчихлээ гэж үү. Ээ чаваас. Бүтэн юм алга. Бааданг нь ч цоо идэж!

-Чи дөнгөж сая уудалж байгаагүй бил үү. Одоо яадаг бил ээ, Жамц минь. Иим ч юм байх гэж дээ хэмээн эхнэр Аюуш нь хэнгэнэж, Жамц баян харин хулганад юу ч үгүй мэрүүлсэн сэмэрхий хэдэн дэвсгэртээ барин халаглана.

Хүмүүсийн сэтгэлд тодоос тод үлдсэн “Хүргэн хүү” киноны энэ хэсгийн орчин цагийн хувилбар нь цахим халдлагад өртөгсөд болж хувирчээ.

Мэдээлэл технологийн салбар хурдтай хөгжиж, санаанд оромгүй гайхалтай боломжуудыг бидэнд олгож буй ч үүнээс урган гарах эрсдэл нь улам нэмэгдэж байна. Тиймээс Монгол Улсад өнөөдөр мэдээллийн цахим аюулгүй байдлаа хангахад ямар бэрхшээл тулгарч буй болон даван туулах гарц шийдлийн талаар “Мобиком корпораци” энэ сарын 16-нд “Кибр аюулгүй байдал 2017” олон улсын форум зохион байгуулсан юм. Төрийн болон хувийн хэвшлийн 49 байгууллагын төлөөлөл оролцсон форумд Японы үүрэн холбооны тэргүүлэгч оператор KDDI корпорацийн цахим аюулгүй байдал хариуцсан ахлах менежер А.Кубота болон Мобиком корпорацийн мэргэжилтнүүд мэдээллийн аюулгүй байдлын систем хөгжүүлэх шаардлага, загвар, эрсдэлийн эх үүсвэрийн талаар мэдээлэл хуваалцлаа.

Мэдээлэл технологийн хөгжлийн сүүдэртэй тал, магадгүй хамгийн аюултай ч байж мэдэх хуурамч аккаунт, фишинг, спам, ransomware гэх үгс сүүлийн жилүүдэд нэн түгээмэл дуулдаж буй. Гэвч асар хурдтай тархах болсон энэ эрсдэлээс өөрийгөө, гэр бүл, байгууллага, улс орноо хамгаалах боломжийн талаар бид тун нимгэн мэдлэгтэй байгаа нь харамсалтай. Байгалийн гамшиг, улс төрийн тогтворгүй байдал, эрчим хүчний үнийн өсөлттэй адил эдийн засаг, санхүүгийн асар их хохирол учруулж буй хүчин зүйлээр цахим халдлага нэрлэгдээд буй. Үүнээс болж 2015 онд зөвхөн Ази, Номхон далайн бүс нутгийн бизнесүүд 81.3 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн. Мөн АНУ-д л гэхэд цахим халдлага ердөө зургаан сарын дотор жижиг бизнесүүдийн 60 хувийг дампууруулж байна. Өнгөрсөн оны байдлаар байгууллагын мэдээлэл алдагдсанаас АНУ 7.1, Их Британи 3.95, Франц 4.72, Япон 3.3 сая ам.долларын алдагдал хүлээжээ. Харин 2019 он гэхэд хохирлын хэмжээ дэлхий даяар 2.1 их наяд ам.доллар болно хэмээн таамаглаж, сэргийлэх арга замаа улс орнууд эрэлхийлж байна.

Төрийн болон хувийн, олон нийтийн ямар ч байгууллага асар их мэдээлэл боловсруулж байж оновчтой шийдвэр гаргадаг, түүнийхээ үндсэн дээр урагшлах нөхцөл бүрддэг. Өөрөөр хэлбэл, мэдээлэл бол өмч. Тиймээс ч мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах, мэдээлэл алдагдахаас сэргийлэхэд юу хийх шаардлагатай талаар маш тодорхой мэдлэгтэй байх хэрэгтэйг мэргэжилтнүүд хэлж байна. Наад зах нь вирусийн хамгаалалттай болон лицензтэй программ хэрэглэх, энэ талын мэдлэг мэдээллээ байнга шинэчилж байхгүй бол “Хүргэн хүү”-ийн мөнгө иддэг оготно орчин цагт зүсээ хувирган таныг, танай байгууллагыг отоод сууж байдаг гэдгийг хэзээ ч мартаж болохгүй.

Мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт, эрсдэл, түүнээс сэргийлэх боломж, арга туршлагын талаар болон ер нь мэдээллийг аюулгүй байдлыг дотоодын байгууллагууд хэрхэн үнэлж, үйл ажиллагаандаа анхаардаг талаар бид форумд оролцогчдоос сэтгэгдэл авсан юм.

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХЗОРИГ

Мэдээллийн эрин зуунд мэдээлэл бол бодит бус хийсвэр өмч болчихлоо. Өмчийн нэг хэлбэр гэсэн үг. Өөрөөр хэлбэл, мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэл огт байхгүй гэх ойлголт дэлхий нийтээр байхгүй. Хэдий том компани ч мэдээллээ алдах эрсдэлтэй байгаа. Харин эрсдэлийг аль болох багасгах тал дээр л ажиллана. Өнөөдөр Монголын хувьд зөвхөн манайх гэлтгүй бүх байгууллагад мэдээллээ алдах эрсдэл өндөр байгаа. Манайх мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнтэй ч өндөр хэмжээнд анхаарал хандуулж одоохондоо чадахгүй байна. Тиймээс 2016, 2017 оныг хэлтсийнхээ хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын жил болгон зарлаад, шүүхийн тогтолцооны мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахаар ажиллаж байна. Энэ чиглэлээр технологи, программ, техник хангамж, сүлжээний хувьд технологи сайжруулалт хийж байгаа. Мөн нууц үг гэх хэдхэн тэмдэгтийн цаана мэдээллээ алдаж, их хэмжээний хохирол амсах асар том эрсдэл байгаа гэдгийг ойлгуулах зэргээр хувь ажилчдын мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг чадварыг сайжруулж эхэлсэн.

УБТЗ-ЫН ДОХИОЛОЛ, ХОЛБОО, СҮЛЖЭЭ, ЭРЧИМ ХҮЧНИЙ АЛБАНЫ ХОЛБОО ХАРИУЦСАН АХЛАХ ИНЖЕНЕР Ч.СЭЛЭНГЭ

-Мэдээлэл тухайн хүний өмч болсон цаг үед амьдарч байна бид. Хувь хүн, айл, албан газар бүрд үүссэн эрсдэлийн талаар “Мобиком корпораци” бидэнд үнэ цэнэтэй мэдээлэл хуваалцлаа.

Бид маш эрсдэлтэй орчинд амьдарч байгаагаа өмнө нь анзаардаггүй байж. Байгууллагын хувьд бол эрсдэл, түүнээс учрах хохирлын дүн олон оронтой тоогоор хэмжигдэх нь мэдээж. Мэдээллийн нууцлал, өмч гэдэг зүйл байгууллагад хамгийн чухал. Манай байгууллага мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгж, инженертэй. Мөн давхар аж ахуйн нэгжтэй гэрээний үндсэн дээр хангуулдаг.

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН ХМТАЦ-ИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ДАРГА Ц.БЯМБА-ОД:

Манай байгууллагын хувьд мэдээллийн аюулгүй байдалд эрсдэлтэй түвшинд байна. Үүний шалтгаан нь ажилчид энэ талаарх мэдлэг, мэдээлэл дутмагтай холбоотой. Цахим халдлагын 70-90 хувь нь дотоод хүчин зүйлээс шалтгаалдаг гэж байна. Өөрөөр хэлбэл, бид халдах нөхцлийг нь бүрдүүлээд байгаа гэсэн үг. Тиймээс хүн бүрийн оролцоо чухал. Манайд уг нь мэдээллийн аюулгүй байдлын журам гэж бий. Гэвч хэрэгжилт их муу. Сүлжээнд 1400 гаруй компьютер байдгийг тэр бүгдийн аюулгүй байдлыг хангахын тулд ажилчдаа нэгдсэн сургалтад хамруулж, удирдлага ч гэсэн дор бүрнээ мэдээллийн аюулгүй байдлаа хангахыг шаардах хэрэгтэй. Манайх удирдах түвшинд ransomeware-д өртөж байсан хэдэн тохиолдол гарсан.

Бид энэ зунаас мэдээллийн аюулгүй байдлаа хангах тусгай сургалт гадна, дотнынхонтой их харилцдаг худалдаа, маркетингийн хэлтэст явуулж эхэлсэн. Гол хүмүүсээ сургаж, тэд маань хэлтэстээ зааж, түгээх маягаар явж байна.

Судлаачийн үг

“Эх орны хишиг”-ийн зарим хувилбар

“Эх орны хишиг” санг бий болгохдоо учрах эрсдэлийг тооцох нь чухал

Олхонуд Баярхүү
Судлаач профессор

ОРШИЛ

Эх орны хишиг сангаас иргэддээ мөнгө хуваарилж, байгалийн их баялгаасаа хувь хүртээх буянт үйлс манайд эхлээд сураг нь тасарсан. Монголын төр, засгаас иргэддээ хандуулсан нийгмийн чиглэлийн бодлогыг дэмжиж, бас ч үгүй хүртэж байдаг хүний хувьд эл бодлогод баяр хүргэж байсансан. Баялгаасаа хувь хүртэх тэр ирээдүй холгүй биз ээ.

Харин энэ удаа арай өөр өнцгөөс дэлхийн эдийн засгийн ерөнхий дэвсгэр дээр, Персийн булангийн Арабын зарим улсын жишээн дээр тайлбарлаж, төр, засгийн удирдлагадаа санаа өгөх, бас хүртэхээр хүсч буй иргэддээ мэдээлэл өгөх үүднээс дараахи өгүүллийг бичлээ. Хүлээн авч эргэцүүлнэ үү?

Эх орны хишгийг байгалийн баялгаасаа бүрдүүлээд ард иргэддээ хуваарилдаг туршлага миний ажиллаж байсан Персийн булангийн Арабын зарим улсад бий. Тэр туршлагаас санаа сургамж авч манайхан эндээ туршиж үзээсэй хэмээн би мөн ч их уриалсан, бичсэн, төр засагтаа хүргэсэн дээ. Үнэхээр байгалиас заясан хөрсөн доорхи тэр их баялаг бол ард түмний, төр засгийн мэдлийн өмч байх нь зүй. Харин тэр баялаг нь ямар эрдэс баялаг болох, ямар аргаар олборлодог, хэр нөөцтэй, хамгийн гол нь ямар дэд бүтцээр дамжин дэлхийн зах зээлд гардаг гээд харьцуулбал манай Монгол ба Персийн булангийн Арабын улсуудын хооронд газар тэнгэр шиг их зөрүү гараад ирнэ.

Тэнд нефть, заримд нь байгалийн хий байна. Олборлох өртөг нь хямд, цооног хоолой хоёр байхад л дэд бүтэц нь босоод ирж байна. Тэнд эх газарт түгжигдсэн улс байхгүй, бүгд далайд гарцтай, энэ нь дэлхийн зах зээлд чөлөөтэй гарах хамгийн том (магадгүй амин чухал нь) боломж нь. Олборлоход хямд төсөр, байгаль орчныг бужигнуулахгүй, далайгаар шууд тээвэрлэдэг түүхий эд тэнд байна. Олсон ашиг нь хуримтлал болж банкинд байршихдаа илүү дөт, тэгээд ч дэлхийн эрчим хүчний нөөцийн ихэнхи нь тэр хэдхэн улсад байгаа хэрэг шүү дээ.

Тэгвэл манайд яг үүний эсрэгээр, хөрсөн дор чулуун нүүрс, зэс, бусад үнэт метал байна. Олборлоё гэвэл уурхай зайлшгүй, маш том нүсэр барилга байгууламж, асар их өртөг бүхий дэд бүтэц хэрэгтэй. Байгаль орчны эрсдэл байнга дагаастай. Магадгүй амин чухал нь гэх тэр боломж (далайд гарц) манайд алга. Хэрэв олборлоод, эсвэл олборлон өөрөө боловсруулаад дэлхийн зах зээлд гаръя гэхэд заавал хоёр хөршөөр дамжиж таарна. Иймд хоёр хөршийн тавих болзол нөхцөлүүд амин чухал хүчин зүйл нь болоод явчихна. Өөрөөр хэлбэл, Персийн булангийн Арабын улсуудтай харьцуулах аваас олсон ашиг нь хуримтлал болж банкинд байрших үйл явц үлэмж хугацаа шаардах ба тэр хүртлээ багагүй зовлон туулна гэсэн үг.

Гэлээ гээд тэгэхээс өөр зам байхгүй, ДНБ-ий талаас илүү нь уул уурхайгаас бүрдэж байгаа, хэтдээ нэмэгдэж ч таарна. Харин арабын тэр улсууд олборлож эхэлмэгцээ л өнөөгийн тэр их жаргалд хүрчихээгүйг дараах баримтууд хэлж байна.

ОРДЫН ЦААНА ИХ ЮМ БИЙ

“Нефтийн Дорно” гэх чихэнд дасаагүй нэр томъёо бүр дэлхийн II дайнаас өмнө гарчээ. Тэр дундаа миний жишээ болгох, очиж үзэн биеэр мэдэрсэн, хоёр ч Хаантай нь биечлэн уулзсан Персийн булангийн хэсэг улсын хувьд тэгж нэрлэгдэх түүхэн нөхцөл нь чухам бүрджээ. Нефть гэх шингэн түүхий эд хамгийн чухлаар тавигдаж ирсэн өөр улс үндэстэн, бүс нутгийг олж заа гэвэл, хэрэв цогцоор нь аваад үзвэл Персийн булангийн Арабын хэсэг улсаас өөр тэгж нэрлэгдэх улс, бүс нутагт байхгүй.

Тэдгээр улсын түүхийг судалж байхад санаандгүй явдлаар энэ нефтийн ид шид эхэлсэн байдаг. Британийн эзэнт гүрний хувьд өөрийн хамгийн том колони Энэтхэгийн ойролцоо усан боомт хайж явтал гэв гэнэт Персийн булан хавиас нефть илэрч, бүс нутгийн нэр хүнд огцом өссөн байна. Ингээд 1930-аад он гэхэд л эндхийн стратегийн ач холбогдлыг их гүрнүүд олон дахин өсгөөд тавьчихаж. Британиас гадна АНУ, Франц, Итали ийшээ сонирхолтой болж, германчууд нэвтэрчээ. Холбоотнууд II дайнд ялалт байгуулахад Ойрхи Дорнодын нефть нь эрчим хүчний гол эх сурвалжийн хувьд шийдвэрлэх үүрэгтэй байсан. 1953 онд Иранд Америк, Британийн оролцоотой төрийн эргэлт хийхэд чухам нефть л гол хөдөлгөгч нь болсон, учир нь Ерөнхий сайд М.Моссадык Anglo-Persian (өнөөгийн British Petroleum) компанийг төрийн мэдэлд авч байж үхлээ бэлтгэсэн аж.

Хожим нь 1973 онд Саудын Араб, Кувейт, Абу-Дабигийн нефтийн ордуудыг европын холбоотнуудтайгаа зөвлөхгүйгээр АНУ булаан авах гэж байж дэлхийг бужигнуулсан. 1991 онд Кувейтыг Иракаас чөлөөлсөн холбоотны дайн байна. Энэ бол Кувейтын Эмирийн нефтийн нөөцийг аврах, гол нь Саддамыг тийш нь оруулахгүй байх шалтгаанаар нөхцөлдсөн. 2003 оноос өрнөсөн Иракийн эрх чөлөө ажиллагаа мөн л нефтиэр нөхцөлдсөн, “Арабын хавар” тойрсон дайн мөргөлдөөн, арилжаа, хуйвалдаан бол тэр чигтээ нефть гэх “хараал идмэр” дээр очиж бууж байна. Гэхчлэн эдгээр жишээ бол нефть тойрсон дэлхийн их бодлогын салаа сэжүүр нь.

КАТАР

Монголтой гайгүй харилцаатай яваа Катар Улсыг жишээлж үзье. Тэр хавьдаа жижиг нь гэх утгаар эхлэн жишээ болгож байна. Энэ улсад дэлхийн шатдаг хийн нөөцийн 15 гаран хувь нь хадгалагддаг. Тэр утгаараа сая хүрэхгүй хүн амтай, 11 437-хон хавтгай дөрвөлжин км бүхий элсэн цөлийн энэ жижигхэн улс орчин үеийн ертөнцөд эрчим хүчний томхон гигант болох зорилтыг тавьсан, зорилгодоо ч хүрсэн байна. 2016 оны байдлаар хүн ам тутамд ногдох ДНБ нь 129 700 ам.доллар. Бараг саяхан хүртэл сувд далайгаас шүүрддэг, энэ хавьдаа хамгийн ядуу нь гэх улс байжээ. 1940-өөд оноос нефть хий олборлож эхлээд 1971 онд тусгаар тогтнолоо зарласны дараахнаас бүс нутгийн хамгийн баян улс болж чаджээ. Нефть, хийгээс олсон орлого (нийт орлогын 80 хувь) нь нийгмийн хангамж руугаа шилжмэгц нийгмээрээ баяжин, улсаас дааж үнэгүй олгох, эдлүүлэх бараа үйлчилгээ ч олширсон байна.

Кувейтын жишгээр явбал ямар бол гэх бодол надад төрсөн, судалж үзэхэд илүүдэхгүй

Үндсэн хүн ам нь оршин суугаа гадаадын хөлсний ажилчдаасаа цөөн, яг одоо орон сууцжуулах, барилгажуулах их ажил өрнөж буй тул гадаадын барилгачид маш олноороо ажиллаж байгаа дүр зураг харагдана билээ. Нэгэнтээ байгалийн асар их хийн дээр суугаагийнх ОПЕК-той төстэй (Нефть экспортолодог орнуудын байгууллага) байгууллага байгуулах замаар дэлхийн ба бүс нутгийн бодлогод жин нөлөөгөө нэмэгдүүлэхийг Катар зорьж байна. ОПЕК нь нефтийн үнийг өсгөж, буулгадаг бол харин тэр шинэ байгууллага нь 20-30 жил байгалийн хийн үнийг тогтвортой барих зорилготой аж.

КУВЕЙТ

Энэ улс бол манайханд харьцангуй танил. Нефтийн нөөцөөр дэлхийд дээгүүрт орох жижиг улс, байршлын хувьд манайтай адил гэж Гадаад хэргийн сайд нь зүйрлүүлэн ярихыг би сонсож байсан. Нөлөө бүх том том хөршүүдтэй, эх газраар Саудын Араб, Ирактай, далайгаар Ирантай хиллэдэг, стратегийн байршилтай. Экспортын нийт орлогын 90 хувийг ганц нефть нь бүрдүүлдэг, гурван сая хүн ам, 17 818 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр, ДНБ-ээс хүн ам тутамд ногдох орлого нь 28 756 ам.доллар (ОУВС-гийн 2016 оны судалгаа).

Дэлхийн нефтийн нөөцийн 10 хувийг эзэмшдэг, жилдээ 2.5 сая баррелийг олборлодог. Тус улсын санхүүгийн актив нь 200 тэрбум ам.доллар гэхчлэн бичвэл хуудас дүүрэн баримт бий. Харин манайхны хүсэхээс цаашгүй байгаа эх орны хишиг гэдгийг арабын ертөнцөд хамгийн түрүүн туршсан (үндэсний баялгийг хуваарилахад бүх кувейтчууд тэгш эрхтэй гэж хуульчилсан), эдийн засаг нь чухамдаа “Нефтийн эдийн засаг” нэрэндээ яг зохицох, ДНБ-ний 75 хувийг улсын сек-торт бүтээдэг тийм нэгэн улс байна. Нефтийн орлогоосоо Нөөцийн ерөнхий сан гэдгийг байгуулж, тэндээсээ хөрөнгө оруулалт хийдэг, Ирээдүй хойч үеийнхэндээ зориулсан санг эндээс санхүүжүүлдэг гэж надад ярьж байсан тэмдэглэлээ сөхөж бичиж байна.

Намайг Кувейтын Эмирт Итгэмжлэх жуух бичгээ барихаар очиж байх үед Кувейтын төр засаг нь нийт оршин суугчдынхаа цалин орлогыг 120 динараар (440 доллар) нэмэх шийдвэр гаргаж байсансан. Тэр нь инфляцтай тэмцэх арга хэмээн Гадаад хэргийн сайд нь надад ярьж байв. Кувейтэд ажил эрхэлдэг гадаадын ажилчдын цалин 50 динараар (138 доллар) мөн нэмэгдэж байсан. Одоогоос 10-аад жилийн тэртээ намайг тэнд очиж байхад хэргээр сонирхоод асуутал тэр улсын оршин суугчдын дундаж цалин 1000 гаруй динар (тэр үеийнхээр 3650 доллар) гэж байв.

Кувейтын жишгээр бол, манайхан “Эх орны хишиг” санг буй болгохдоо учрах бүх эрсдэлийг урьдчилан тооцох үндсэн дээр хязгааргүй их мөнгөн хуримтлал эхлэн бий болгох улмаар төр нь түүнийгээ хатуу хянаж, түүнээсээ хөрөнгө оруулалтын эх сурвалж (хөрөнгө оруулалтын орлого) гаргах, үндэсний бизнесийг дэмжих, гадаадад байршуулах, хөрөнгийн бирж босгох хэрэгтэй. Харин иргэдэд хүртээх санг хойч үедээ гэдгээр тусгай сангаар тусад нь, бараа ажил үйлчилгээг төр даах замаар (гэрэл цахилгаан, ус, утасны мөнгө төр даах гэхчлэн) тусдаа хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй гэж кувейтын нэг эдийн засагч надад ярьж байлаа. Харин иргэддээ бэлэн мөнгө шууд тараах тухай ганц ч үг цухалзаагүй юмсан.

ЭМИРАТ

Нефть олборлолтын оргил үеийг далимдуулан гадаадаас хөлсний ажилчин авсаар хүн амынхаа 80 хувийг гадаадынхан болгочихсон улс Персийн буланд ганц Эмират (нийт хүн ам нь гурван сая гаран, нутаг дэвсгэр нь 77 700 хавтгай дөрвөлжин км) юм билээ. Хотуудын гудамжаар явгаар зорчих, эсвэл мөргөлийн цагаар гудамжинд үзэгдэх нь зөвхөн гадаадынхан, тэр утгаар энэ хавьдаа хамгийн либерал улс, бусад шашин шүтлэгийг зөвшөөрдөг, эрх баригчдаа өөрсдөө шууд сонгодог цорын ганц улс нь хүртэл Эмират байв.

Анхандаа загас агнуур, сувд шүүрддэг ядуувтар улс байснаа 1950-иад онд нефть нээгдэж, олборлон баяжсаар хосгүй хөгжлийг бүтээж, нефтийн экспортыг эрүүлийг хамгаалах, боловсрол, үндэсний дэд бүтцийн хөгжил рүү шууд чиглүүлж чадсанаараа алдаршжээ. Хүн амын амьдралын чанар булангийн орнууд дотроо хамгийн дээгүүр нь, 2016 оны судалгаагаар ДНБ-ээс хүн ам тутамд ногдох орлого нь 67 700 ам.доллар. Бусад улсаасаа ялгарах нэг онцлог нь тэнгэр баганадсан сүрлэг барилга, тансаг зочид буудал, жуулчны баазуудыг байгуулах замаар үзүүлэнгийн эдийн засгийг буй болгосон, эдийн засаг нь дөрвөн гол онцлогтой. Төрийн маш гүнзгий оролцоо, нефтийн орлогын хэт хамаарал, баялаг тансаг амьдралдаа илтгэх их эрмэлзэл, холбооны улсын гишүүн-вант улсуудын эдийн засгийн бодлогыг хооронд нь зохицуулдаггүй, чөлөөтэй тавьсан зэрэг нь ийм их амжилтад хүргэсэн хэмээн надад ярьж байв.

Энэ бүхнээс уншигч та дүгнэлт хий. Олборлоход хямд төсөр, байгаль орчныг бужигнуулахгүй, далайгаар шууд тээвэрлэдэг, тэр утгаар олсон ашиг нь хуримтлал болж банкинд байршихдаа илүү дөт арабын улсуудын туршлагыг шууд буулгах бус, “Эх орны хишиг сан”-г бий болгоод үйл ажиллагааг нь эхлүүлэхдээ Кувейтын жишгээр явбал ямар бол гэх бодол надад төрсөн, судалж үзэхэд илүүдэхгүй дэг шүү!

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Баяртогтох

Дэд бүтэц

Төв Азийн хамтын ажиллагааны шинэ эрин үе

Дэд бүтцийн салбарт шинээр нэвтэрч буй технологийг дэмжих хэрэгтэй

С.Батсайхан / ЗГМ©

КАРЕК хөтөлбөр нь ирэх он жилүүдэд илүү үр өгөөжтэй, илүү хамааралтай байхын тулд илүү өргөн хүрээг хамарч ажиллах шаардлагатай.

Такехико Накао
АХБ-ны Ерөнхийлөгч

Төв Ази нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өрнөл ихтэй бүс нутаг билээ. Сүүлийн 20 жилийн туршлагаас харахад бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хөгжлийн зорилтуудыг бодит болгоход ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна.

Төв Азийн Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр буюу КАРЕК нь 2001 онд хэрэгжиж эхэлсэн үүнээс хойш тус бүс нутгийн хөгжлийг урагшлуулахад бодитой хувь нэмэр оруулсаар ирсэн. Гишүүн улс орнуудын тоо тууштай өссөөр өдгөө 11-т хүрээд байна. Өнөөдрийг хүртэл хөтөлбөрийн хүрээнд тээвэр, эрчим хүчний дэд бүтцийг сайжруулах болон хил дамнасан худалдааг идэвхжүүлэхэд зориулж нийт 30 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Үүний гуравны нэг буюу 10.5 тэрбум ам.долларын хөтөлбөрийг эхнээс нь дэмжиж ирсэн Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн байна.

Бүс нутгийн улс орнууд хурдацтай хөгжихийн сацуу томоохон бэрхшээлүүдтэй тулгарсаар байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын хам нөлөө, газрын тос, байгалийн хийн үнийн уналт зэрэг нь бүс нутгийн нөхцөл байдлыг илэрхий хүндрүүлсэн. Дэлхий нийтийн өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт ч мөн бүс нутгийн хувьд томоохон сорил болоод байна. Хил хязгаарыг үл хайхрах эдгээр бэрхшээлүүдийг даван туулж, хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн орчныг зөв чиглүүлэхэд хамтын ажиллагаа юунаас ч илүү чухал ач холбогдолтой.

КАРЕК хөтөлбөр нь ирэх жилүүдэд илүү үр өгөөжтэй, илүү хамааралтай байхын тулд өргөн хүрээг хамарч ажиллах шаардлагатай тулгарав.

Ард иргэд, хөгжлийн бодлого болон төсөл хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог хангаснаар өөрт орших буй асар их боломжийг бүрэн нээхэд бэлэн байгаагаа гишүүн орнууд илтгэлээ. Үүний нотолгоо нь энэ оны 10 дугаар сарын 27-ны өдөр Тажикистан Улсын Душанбе хотноо КАРЕК 2030 Стратегийн баримт бичгийг гишүүн орнууд санал нэгтэйгээр баталсан явдал юм. Ирээдүйн өсөлт, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн суурийг тавих дараах дөрвөн боломж энэхүү хөтөлбөрт тусгалаа олсон хэмээн үзэж байна.

Нэг, тээвэр, эрчим хүч, худалдааг хөнгөвчлөх зэрэг уламжлалт хамтын ажиллагааны чиглэлүүдэд үзүүлэх дэмжлэгийг гүнзгийрүүлэх. Сайн чанарын авто болон төмөр зам барих, эрчим хүчний хангамжийг найдвартай болгох, шинэ зах зээлд нэвтрэх бизнесийн боломжийг бүрдүүлэх зэргээр хөгжлийн суурь өгөгдлүүдийг бий болгохгүйгээр бүс нутгийн хамтын ажиллагааны өгөөжийг нэмэгдүүлэх боломжгүй.

Дэд бүтцийн салбарт шинээр нэвтэрч буй технологийг дэмжих чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, түүнийгээ зохистой хууль эрх зүйн шинэчлэлтэй хослуулан хэрэгжүүлэх аваас тус бүс нутгийн дэлхийн үнэ цэнийн гинжин хэлхээнд нэгдэн орох явц хурдасч, цэвэр ба сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Хоёр, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс макро эдийн засгийн бодлогын хэлэлцээг гишүүн орнуудын дунд өрнүүлэх шаардлага тулгамдсан асуудал болоод байна. КАРЕК хөтөлбөрийн үр дүнд дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон түүний бодлого төлөвлөлтийг хэлэлцдэг бодитой бөгөөд уян хатан механизм бий болсон.

КАРЕК 2030 стратегийн барим бичигт тусгагдсан банк, санхүүгийн салбар болон зах зээлийн зохицуулалтын талаар харилцан туршлага солилцох форум зэрэг шинэ санаачлагуудыг хэрэгжүүлснээр бүс нутгийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг хадгалах, мөчлөг дагасан эдийн засгийн хямралын үр дагаврыг зөөллөхөд дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ.

Төв Азид аялал жуулчлал, хөдөө аж ахуйн экспортыг хөгжүүлэх асар их нөөц бий

Гурав, Төв Азийн бүс нутаг өөрт буй боломжийг бүрэн ашиглаж жинхэнэ ёсоор хөгжин цэцэглэхийн тулд хамтын ажиллагааны шинэ чиглэлүүдийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай. КАРЕК 2030 стратегийн баримт бичигт дурьдагдсан аялал жуулчлал, хөдөө аж ахуй, усны нөөц, эрүүл мэнд, боловсролын салбаруудад чиглэсэн бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ санаачлагуудыг дэмжин ажилласнаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх улс орнуудын хүчин чармайлтад нэмэр болно. Хамтын ажиллагааг эрчимжүүлэх аваас гишүүн орнуудын НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн конвенцийн талуудын 21 дүгээр бага хурлын шийдвэрийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхэд дөхөм болно.

Төв Азийн бүс нутагт хил дамнасан аялал жуулчлал, нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн экспорт, боловсролын солилцоог хөгжүүлэх асар их нөөц боломж байна. Энэхүү нуугдмал боломжуудыг нээх цорын ганц арга нь улс орнуудад хамтран ажиллаж, харилцан туршлага солилцох боломжийг олгох бүс нутгийн индэр бий болгох явдал билээ.

Төгсгөлд нь хэлэхэд, Төв Азийн бүс нутаг цаашид хөгжих эсэх нь хүн амынхаа чадавхийг хэрхэн бэхжүүлэхээс бүрэн хамаарна. Хүнээс хүнд чиглэсэн харилцааг хөгжүүлснээр бүс нутаг дахь харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн, бизнес хоорондын харилцаа холбоог бэхжүүлснээр хувийн хэвшлийн хөгжлийг хөшүүрэгдэж, ажлын байр олноор бий болох юм.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлснээр ажилчид өөрсдийн ур чадвараа дээшлүүлэх, шинэ ажлын байранд очих нөхцөлийг бүрдүүлдэг. КАРЕК 2030-ийн хүрээнд ур чадварын хэрэгцээ шаардлага, ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг нэгтгэсэн бүсийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг хөгжүүлэхийн сацуу дээд боловсрол болон техник мэргэжлийн сургалтуудад хил дамнан хамрагдах боломж бүрдүүлж ажиллахаар шийдвэрлэсэн нь туйлын сайн хэрэг.

Шинэ стратеги нь хөтөлбөрт оролцогч талуудыг нэг дор хуран цуглуулж хөгжлийн чухал асуудлаар сайд нарын болон бусад өндөр түвшинд хэлэлцээ хийх боломжийг олгодог чадамжийг улам бэхжүүлэх болно. Энэхүү яриа хэлэлцээг КАРЕК Хүрээлэнгээс хийгдэх сайн чанарын судалгаанд тулгуурлан өрнүүлэх нь нэн чухал. КАРЕК Хүрээлэн нь боловсрол, эрүүл мэнд, санхүү, эдийн засгийн тогтвортой байдал зэрэг чиглэлээр гишүүн орнуудын чадавхийг бэхжүүлэх чиг үүрэг бүхий гишүүн орнууд, хөгжлийн түнш байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн цоо шинэ засгийн газар хоорондын байгууллага юм.

КАРЕК 2030-ийн хамрах хүрээ өргөжсөнөөр Азийн хөгжлийн банк зэрэг хөгжлийн түншүүдийн хувьд тус бүс нутгийн хөгжил дэвшлийн төлөө илүү тууштай, өргөн цар хүрээг хамран ажиллах боломж бүрдэж байна. Түүнчлэн "Нэг бүс-нэг зам" санаачилга зэрэг өөр бусад бүс нутгийн хөтөлбөрүүдтэй уялдаатай ажиллах, шинэ түншлэлүүдийг цогцлоох сайхан боломжийг нээж байна.

АХБ-ны зүгээс шинээр батлагдсан КАРЕК 2030 стратегид тусгагдсан үйл ажиллагааг дэмжихэд зориулж таван тэрбум ам.долларын санхүүжилтийг дараагийн таван жилд олгохоор боллоо. Тус банкнаас КАРЕК-ийн авто замын коридорыг хөгжүүлэх 800 сая ам.долларын дүн бүхий олон шатлалт санхүүжилтийн хөтөлбөрийг Пакистан улстай хамтран хэрэгжүүлэхээр дөнгөж саяхан батлаад байна. Улмаар ирэх онд Туркменистан-Афганистан-Пакистаныг холбосон эрчим хүчний дамжуулах шугамын төслийн эхний үе шатанд зориулж 150 сая ам.долларын санхүүжилт өгөх болно. Түүнчлэн, АХБ-ны зүгээс КАРЕК 2030-д тусгагдсан хөдөө аж ахуй, аялал жуулчлал, төмөр зам зэрэг салбаруудад хэрэгжих бүс нутгийн төслүүдийн талаарх яриа хэлэлцээгээ аль хэдийн эхлүүлээд байна.

Бид бүх гишүүн орнууд болон хөгжлийн түншлэгч бусад байгууллагуудаасаа КАРЕК 2030 стратегийг амжилттай хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллахыг хүсэж байна.

КАРЕК хөтөлбөрийн гишүүн орнуудын хамтын хүчийг нэгтгэн чиглүүлснээр газарзүйн өвөрмөц байршил, дэлхийн зах зээлтэй дөхөм байдлаа оновчтой ашиглаж үр өгөөжийг нь хүртэхэд энэхүү шинэ стратеги дэмжлэг үзүүлэх болно. Бүс нутаг дотроо болон Европын орнуудтай, цаашлаад бусад бүсийн улс орнуудтай уялдаж, худалдаа арилжааг нэмэгдүүлэх асар их боломж байна хэмээн үзэж байна.

КАРЕК 2030 нь Төв Азийн бүс нутгийн хөгжил дэвшил, тогтвортой байдал, цаашдын цэцэглэлтийг дэмжих бодит боломж юм. Улс орнууд болон хөгжлийн түншүүд нягт хамтран ажиллаж гэмээнэ тус бүс нутаг, түүний ард иргэдийн хүртэх ёстой гэрэлт ирээдүйг цогцлоож чадна.

Рено - удахгүй Монголд

RENAULT
Passion for life

Рено корпораци өргөжин тэлсээр байна

"Рено-Ниссан" альянс буюу холбоо нь 2017 оны байдлаар автомашин үйлдвэрлэлээрээ дэлхийн хэмжээнд нэгдүгээрт жагсах болсон билээ. Тус холбоо нь олон улсын эдийн засгийн тавцанд голлох тоглогчид болох томоохон автомашин үйлдвэрлэгч компаниудын хувьцааны тодорхой хувийг эзэмшиж, үйл ажиллагааг нь удирдан хянадаг. Тухайлбал, Рено компани нь дангаараа БНСУ-ын Samsung Motors-ын 80.1 хувь, Япон Улсын Nissan Motor-ын 43.4 хувь, Румын Улсын Dacia үйлдвэрийн 99.43 хувь, ОХУ-ын АвтоВаз-ын 50 гаруй хувь, Daimler компанийн 3.1 хувь, Швед Улсын AB Volvo-ийн 20.5 хувийг тус тус эзэмшиж байна. Тус компани нь суудлын болон ачааны автомашинуудаа "Renault", "Samsung", "Dacia" гэсэн гурван үйлдвэрийн тэмдэглэгээтэй гаргадаг.

Москва хот дахь Рено-гийн үйлдвэр 2007 онд 69 мянга автомашин үйлдвэрлэж байсан бол 2012 онд 167.406 мянган автомашин үйлдвэрлэсэн нь өмнөх жилүүдийнхээс даруй 19 хувиар өсч, Рено корпорациас тус үйлдвэрт хийсэн хөрөнгө оруулалт нь 480 сая еврод хүрсэн байна. 2015 оны нэгдүгээр сарын 28-ны өдөр тус үйлдвэр нэг сая дахь автомашинаа үйлдвэрлэв. Энэ оны байдлаар тус үйлдвэр нь Renault Duster, Renault Latitude, Renault Kaptur, Nissan Terrano загварын автомашинууд үйлдвэрлэж тэдгээр нь ОХУ-ын зах зээлд маш амжилттай борлогдохын зэрэгцээ экспортын хэмжээ нь огцом өсч байна.

Рено корпораци 2016 онд үйл ажиллагааныхаа стратегийн дунд хугацааны зорилтдоо, дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн тогтворгүй байдлыг үл харгалзан 129 оронд үйл ажиллагаа явуулж буй зах зээлд эзлэх хувь хэмжээгээ улам нэмэгдүүлж, байр сууриа бэхжүүлнэ хэмээн тодорхойлсон байна. Корпораци энэ онд санхүү, үйлдвэрлэлийнхээ өсөлтийг тогтвортой барихын тулд шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, олон улсын туршлага судлалыг хөгжил дэвшилтэй уялдуулахыг чухалчилж ажиллажээ. Өнөөдрийн байдлаар Рено корпорацийн дэлхийн зах зээлд гаргаж буй суудлын автомашинуудын хамгийн их борлуулалттай таван машиныг дурдвал, нэгдүгээр байранд Clio (418.728 ширхэг), Sandero (402.100 ширхэг), Logan (334.139 ширхэг), Duster (326.294 ширхэг), Megane (253.246 ширхэг) байна.

"Оны шилдэг Европын автомашин" наадмын зургаан удаагийн шагналт Рено корпораци нь Euro NCAP ослын туршилтаар хамгийн аюул багатай автомашинаар шалгарч "Таван од"-ын эзэн болж хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг өндөр түвшинд хадгалж чадсан амжилттай. Энэхүү туршилтын гол шалгуур нь автомашины тээж буй бүх зорчигчийн ба бага насны хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан эсэхийг сорьдог байна.

Улаанбаатар

Төсвийн орлогын 61 хувийг хувь хүний орлогын албан татвар бүрдүүлж, үлдсэн хувийг хуулиар тогтоосон хязгаарлагдмал эх үүсвэр бүхий орлого бүрдүүлж байна.

Б.Ганбаяр/ЗГМ©

Нийслэлийн төсвийг 63.7 тэрбумаар нэмэгдүүлнэ

Орон нутгийн хөгжлийн сангаас 16.3 тэрбум төгрөг төсөвлөв

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Нийслэлийн 2018 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд буюу энэ сарын 25-ны дотор НИТХ-д өргөн барих учиртай. Хуульд заасны дагуу ирэх сарын 5 гэхэд нийлэлийн төсөв батлагдах ёстой.

Тэгвэл нийслэлийн ирэх оны төсвийн орлогыг 63.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, урсгал зардлыг 203.1 тэрбум төгрөгөөр бууруулахаар төсөвт тусгажээ. Мөн улсад төвлөрүүлэх орлогыг энэ оныхоос 57.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр боловсруулсан байна. Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүүгийн хэлж байгаагаар энэ жил Орон нутгийн хөгжлийн сангаас нийслэлд 16.3 тэрбум төгрөг олгохоор төлөвлөсөн. Үүнээс 30 хувийг нь дүүргүүдэд, үлдсэнийг нийслэлд зарцуулах аж. Түүнчлэн агаарын бохирдолд 3.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

- **Ирэх хавар СХД-ийн 3000 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулахаар болжээ.**
- **Нийслэлийн төсвөөс агаарын бохирдолд ирэх жил 3.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.**
- **Вокзалийн 1000 автомашины зогсоолыг нүүлгэж, Төмөр замаас шинэ цогцолбор байгуулахаар болов.**

Харин Сангийн яаманд хүргүүлснээр нийслэлийн төсвийн нийт орлогыг 729.9 тэрбумаар, суурь орлогыг 660.9 тэрбумаар, суурь зарлагыг 323.2 тэрбум төгрөгөөр тус тус тооцсон байна. Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас улсад төвлөрүүлэх орлогыг 208.5 тэрбум төгрөг байхаар хянаж тооцжээ.

Нийслэлийн төсвийн орлогын дийлэнх хувийг буюу 61 хувийг Хувь хүний орлогын албан татвар бүрдүүлж байгаагийн 50 орчим хувийг цалин хөлс болон түүнтэй адилтгах ХХОАТ дангаар эзэлж байна. Харин үлдэх хувийг үл хөдлөх хөрөнгө, буу, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл, газар, ус гэх мэт хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулдаг хязгаарлагдмал эх үүсвэр бүхий орлого бүрдүүлж байгаа аж.

Тэгвэл нийслэлийн төсвийн зарцуулалтын асуудалд иргэд шүүмжлэлтэй хандав. Тухайлбал, өнөөдрийг хүртэл нийслэлийн төсвийн зарцуулалт нууц, бүтээн байгуулалт байхгүй байгааг шүүмжлэв. Мөн үлдсэн 2.5 жилд юу хийх эсэх талаар нийслэлийнхнээс ам асуув.

Нийслэлийн Иргэний танхимд болсон нээлттэй хэлэлцүүлгийн үеэр иргэд Баянзүрх дүүрэгт байрлах Да-хүрээ захыг шинэ авто худалдааны төв рүү нүүлгэн шилжүүлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх, хүн ам ихтэй дүүргийг хоёр хуваах асуудлыг онцолсон юм. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн 24, 32 дугаар хороонд гэрэлтүүлэг, хаягжилт байдаггүй бөгөөд одоог хүртэл эрчим хүчинд холбогдоогүйгээс гэмт хэргийн гаралт нэмэгдэх болсон байна. Чингэлтэй дүүргийн есдүгээр хороонд байрлах Цагаан байрыг 2008 онд дахин төлөвлөлтөд хамруулахаар болсон ч өнөөдрийг хүртэл барилгын ажил эхлээгүй бөгөөд түр хугацаанд хойшлогдсон гэх үгээр халхалсаар өдийг хүрчээ. Тэгвэл энэ талаар нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын асуудлыг хариуцсан орлогч дарга П.Баярхүү "Энэ жил шинээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхгүй. Харин хуучин эхлүүлсэн ажлаа 2018 ондоо багтаж гүйцэтгэж дуусгана. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил зогсоогүй, үргэлжилж байгаа. Учир нь иргэдэд ямар нэг хохирол учруулахгүйн тулд энэ онд концессийн гэрээгээр үйл ажиллагаа нь 30 хувьд хүрээгүй дахин төлөвлөлтийн бүх ажлыг зогсоосон. Иймээс өмнө нь гарсан алдааг давтахгүйн тулд зураг төсөл, дэд бүтэц зэргийг сайтар нягталж байгаа. Одоогийн байдлаар Чингэлтэй дүүрэгт л дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж байна. Түүнчлэн өнгөрсөн жил түрээсийн орон сууцыг ашиглалтад оруулж 135 өрхийг байртай болгосон бол энэ жил 156 болж нэмэгдүүлсэн. Удахгүй 300 гаруй ахмадыг орон сууцанд оруулна. Ирэх хавраас СХД-т баригдаж байгаа 3000 айлыг түрээсийн орон сууцанд хамруулна" гэв.

Мөн тэрбээр иргэдийн асуусан Да-хүрээ захыг нүүлгэн шилжүүлэхэд бизнес эрхлэгчид, дүүргийн төлөөлөгчид дургүй байгаа ч тэмцэлдсээр байгаа. Хотын даргын ганц хийх зүйл нь захирамжаа цуцлах сонголт үлдээд байгааг дуулгав.

100 орчим сургууль, цэцэрлэг барих хөрөнгө бүрдсэн

Одоогийн байдлаар Баянгол дүүргийн нутагт орших Вокзалийн 1000 автомашины зогсоолыг Авто худалдааны цогцолбор руу нүүлгэхээр болж, оронд нь Төмөр замаас шинэ цогцолбор байгуулахаар болсон байна. Харин сургууль, цэцэрлэгийн тухайд барилга байгууламж барих боломжгүй 72 байршлыг цуцалж, 30 байршилд шав тавьчихсан байгаа аж. Ирэх хавраас эдгээр сургууль, цэцэрлэгийн барилгын ажлыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Боловсролын газартай хамтран судалгаа хийн, үргэлжлүүлэх юм. Түүнчлэн Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороонд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр цэцэрлэг барихаар болсон байна. Ерөнхийдөө ирэх онд 100 орчим сургууль, цэцэрлэг барих хөрөнгө хангалттай бүрдсэн гэж нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын асуудлыг хариуцсан орлогч дарга П.Баярхүү хэлэв. [ЗГМ]

БАЙР СУУРЬ

Хүүхдүүдээ анхаарахыг ОУ-ын байгууллагууд сануулав

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Монгол Улс хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээг яаралтай авахыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо шаардаж буйгаа илэрхийллээ. Учир нь өнөөдөр манайд хүүхдээр морь унуулах, албадан хөдөлмөр эрхлүүлэх зэргээс авахуулаад эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх болон хүүхдийн эрхэнд халдсан эдийн засгийн мөлжлөг газар аваад буй. Үүнээс болоод өвлийн улиралд томуу, томуу төст өвчний шинж тэмдэг зургаа дахин нэмэгдэж, бронхит болон астма хүүхэд багачуудын дунд нэмэгдэж байгаа нь тэдний сурах, хөгжих боломжийг хязгаарлахад хүргэдэг байна. Тиймээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад заасанчлан жил бүр арваннэгдүгээр сарын 1-нээс тавдугаар сарын 1 хүртэл хурдан морь, уяа сунгаа, үсэргээ, уралдаанд хүүхдийг оруулахгүй гэдэг зүйл заалтаа барихыг хүсэж байгаа аж. Ийнхүү хүүхдийн амь насанд аюул учруулсан этгээдэд хариуцлага тооцдог байхыг хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагууд зөвлөлөө.

Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газрыг энэхүү дүгнэлт зөвлөмжийн харилцан хамааралт байдлыг анхааран ажиллахыг сануулснаас гадна хүүхдийн эрхийг хамгаалахад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай гэдгийг онцолсон юм. [ЗГМ]

Уул уурхай

Уул уурхай зөвхөн эрчүүдийн салбар биш

Уул уурхайд хүйсийн тэгш байдлыг хангаж, жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулах нь салбарын гүйцэтгэл болон нийгмийн хувьд өндөр үр өгөөжтэй.

С.Батсайхан / ЗГМ©

Өсөлт, хүртээмжийг тэлэхэд хүйсийн зөв харьцааг тогтооно

З.Цэлмэг
@tselmegZGM

Газар доор ажилладаг эсвэл шороо чулуу зөөдөг тул уул уурхай нь зөвхөн эрэгтэйчүүд давамгайлсан салбар гэх уламжлалт ойлголтоо өөрчлөх цаг ирснийг техник технологийн хөгжил, нийгэм шаардаж байна. Тиймээс ч ДНБ-ий дийлэнхийг бүрдүүлдэг уул уурхай, эрдэс баялгийн салбарын үр өгөөж, хүртээмжийг нь хүйсийн ялгаварлалгүй тэлэх бодлого 95 жилийн түүхтэй энэ салбарт боловсруулах хэрэгтэй болох нь.

Өнөөдөр 81 улс орны эдийн засгийн өсөлтөд зонхилох үүрэг гүйцэтгэдэг эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэл дэлхийн ДНБ-ий дөрөвний нэгийг бүрдүүлж, 3.5 тэрбум хүнийг тэжээдэг. Тиймээс ч эдийн засгийн сонирхол ихтэй энэ салбарт эмэгтэйчүүд хүчин зүтгэх нь нэмэгдэж байна.

Хүн төрөлхтний түүхэнд эмэгтэйчүүд хад чулуутай ажиллаж, газрын тос олборлох салбарыг удирдахын тулд магадгүй олон зуун жил зарцуулсан байх. Харин Монголд энэ түүх хэдхэн арван жилээр л хэмжигдэж буй. Налайхын нүүрсний уурхайгаар эх сууриа тавьсан Монголын уул уурхайн техник, нарийн мэргэжлийн, удирдах түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцаа ямар байвал энэ салбарын эдийн засгийн үр өгөөж их, өсөлттэй, хүн бүрд хүртээмжтэй байх ёстойг боловсруулах шаардлагатай байна гэдгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал онцлов. Товчхондоо хүйсийн тэгш оролцоог хангах нь эрдэс баялгийн салбарын бодлогын нэг шинэ чиг баримжаа болж хувирлаа.

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛДАГ

Дэлхийн олон орны судалгааг харахад олборлох салбарын 10 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлдэг гэх тоо байдгийг өнгөрсөн баасан гарагт болсон "Эрдэс баялгийн салбар ба жендэр" сэдэвт хэлэлцүүлгийн үеэр албаны эх сурвалж онцолсон. Манай орон ч дэлхийн дундажтай ойролцоо аж. Харин Үндэсний статистикийн хорооны Хөдөлмөр эрхлэлт, Статистикийн нэгдсэн сангийн энэ оны мэдээллээс харахад энэ харьцаа 5:1 байна.

Гэхдээ газрын тосны салбарт бол эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс илт давуу байгааг албаныхан хэлж байна. Хамгийн сүүлийн үеийн байдлаар газрын тосны салбарт хүчин зүтгэж буй 4252 хүний 65.9 хувь, удирдах түвшний бараг 23 хувь эмэгтэй байна. Геологийн салбарын ажиллах хүчний 16.3, хүнд үйлдвэрийн 5.6 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж буй аж. Харин удирдах түвшинд дунджаар 16.6-25 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа юм. Тэгвэл уул уурхай өндөр хөгжсөн Австралид энэ тоо 16 хувь байдаг бөгөөд дээд удирдлагын хоёр, гүйцэтгэх удирдлагын 12.3 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг байна. Ер нь уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо Хойд Америк, Африкт их.

Эрдэс баялгийн салбарт ажилладаг эмэгтэйчүүдэд цалин хөлсний ялгаварлал байдаг. Үүнийг арилгаж, тэгшитгэхийг хувийн хэвшлээс шаардах нь учир дутагдалтай. Тиймээс төрийн өмчийн компаниудын боловсон хүчний бодлого, цалингийн системд хүйсийн тэгш байдлыг хангахад яам арга хэмжээ авах шаардлагатай байгааг хэлэлцүүлгийн үеэр оролцогчид анхааруулсан юм. "Уул уурхай дахь эмэгтэйчүүд" ТББ-ын судалгаагаар манай улсын уул уурхайн салбарт ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн зөрүү 5:4 харьцаатай байгаа аж. Эрдэс баялгийн салбарт эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж буй. Юуны өмнө, салбар бүрд эмэгтэйчүүдийн манлайлал нэмэгдэх хандлага дэлхий даяар өрнөж байна. Мөн техник технологийн дэвшил ч эмэгтэйчүүдэд уул уурхайд илүү ажиллах нөхцөл бүрдүүлж буйг "Энержи Ресурс" ХХК-ийн төрийн байгууллагын харилцаа, зөвшөөрөл олгосон захирал З.Сугармаа илтгэлдээ дурдсан.

Нөгөөтэйгүүр, дэлхийн зах зээлд уул уурхайн түүхий эд нийлүүлэгч улсын хувьд энэ салбарын хөдөлмөрийн зах зээл тун мэдрэг гэдгийг ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн захирал Б.Чинзориг учирласан. Өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өсөнгүүт элсэгчдийн тоо хүйс харгалзахгүй нэмэгддэг байна. Тиймээс цаашид жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулахад зайлшгүй анхаарах шаардлагатай зүйлсийн нэг нь боловсон хүчний бэлтгэл юм.

Өнөөдөр Монгол Улс боловсрол, эрүүл мэнд, нийгэм хамгаалал гээд долоон салбарт баримтлах жендэрийн бодлогоо боловсруулсан. Харин уул уурхайн салбар найм дахь болж буй аж. Уул уурхайд хүйсийн тэгш байдлыг хангаж, жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулах нь салбарын гүйцэтгэл болон нийгмийн хувьд өндөр үр өгөөжтэй байна гэдгийг МУИС-ийн ШУС-ийн профессор А.Солонго эрдэс баялгийн салбарын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх илтгэлдээ дүгнэжээ.

Харин жендэрийн тэгш бус байдал, түүнээс үүдсэн үр дагавар их ажиглагддаг уул уурхайн дэд салбар болох бичил уурхайн жендэрийн нөхцөл байдлын талаар үргэлжлүүлэн хүргэх болно. [ЗГМ]

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Хүйсийн тэгш байдлыг хангах нь цоо шинэ зүйл

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалаас дараах зүйлсийг тодрууллаа.

-Уул уурхайн салбарт жендэрийн асуудлыг яагаад хөндөх болов?

-Жендэрийн асуудлыг олон улсын байгууллагууд хөнддөг байснаас бус төрийн байгууллагууд нэг их ярьдаггүй байж ээ. Тийм учраас бид санаачилгыг гартаа авч, эрдэс баялгийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бодлого боловсруулахад анхаарах тухай өнөөдөр хэлэлцэж байна. Уул уурхай бол ажлын онцлогоос хамаарч эрэгтэйчүүд давамгайлсан салбар. Өөрөөр хэлбэл, бидэнд хүйсийн тэгш байдал гэдэг шинэлэг зүйл.

-Монголд өнөөдөр энэ салбар дахь хүйсийн тэгш байдал ямар байна вэ?

-Манай уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь 10 хувь байна. Энэ нь дэлхийн дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлт. Эрдэс баялгийн салбарт хүйсийн тэгш байдлыг хангах нь өнөөдөр нийгмийн захиалга болоод байна. Нийгэм хөгжихийн хэрээр жендэрийн асуудал гарч ирж байна. Тийм учраас хүйсийн тэгш эрхийг эрдэс баялгийн салбарт хэрэгжих боломж нөхцөлийг бодлогын түвшинд хангах хэрэгтэй. Харин өнөөдөр олон улсын болон мэргэжлийн байгууллага, холбоод, жендэрийн зөвлөхүүд цуглаж үнэтэй санал зөвлөмж өглөө. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаад явах юм. [ЗГМ]

ЗГМ ИНФОГРАФИК



	Зөрүүгүй	Бага зэрэг	Мэдэгдэхүйц зөрүүтэй
Удирдах түвшинд	83%	15 %	2%
Мэргэжлийн ажилчдын	79%	19%	2%
Техникийн ажилчид	88%	10%	2%

МУИС©

ENTREPRENEUR - 2017 шалгаруулалтад материал авч эхэллээ

Монгол улсын, эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж байгаа онцлох аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчдийг шалгаруулан өргөмжилдэг "Entrepreneur" арга хэмжээ нь 21 дахь жилдээ зохион байгуулагдах гэж байна.

"ENTREPRENEUR 2017" арга хэмжээг дараах номинаци, үзүүлэлтүүдийн дагуу шалгаруулна. Үүнд:

A. Гран При шагнал -1 аж ахуй нэгж
Оны онцлох -10 аж ахуй нэгж

B. Номинациуд:

1. Үндэсний үйлдвэрлэгч Энтрепренер
2. Экспортлогч Энтрепренер
3. Хөрөнгө оруулагч Энтрепренер
4. Импортлогч Энтрепренер
5. Сайн засаглалыг хэрэгжүүлэгч Энтрепренер
6. Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч Энтрепренер
7. Дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжигч Энтрепренер
8. Инноваци нэвтрүүлэгч Энтрепренер
9. Гарааны бизнес эрхлэгч Энтрепренер
10. Жижиг дунд үйлдвэрлэгч Энтрепренер
11. Бичил бизнес эрхлэгч Энтрепренер

Тодорхой салбарын Entrepreneur номинациуд:

1. Уул уурхайн салбарын Энтрепренер
2. Худалдааны салбарын Энтрепренер
3. Барилгын салбарын Энтрепренер
4. Банкны салбарын Энтрепренер
5. Банк бус санхүүгийн салбарын Энтрепренер
6. Даатгалын салбарын Энтрепренер
7. Үл хөдлөх хөрөнгийн салбарын Энтрепренер
8. Мал аж ахуйн салбарын Энтрепренер
9. Газар тариалангийн салбарын Энтрепренер
10. Боловсролын салбарын Энтрепренер
11. Хөнгөн үйлдвэрийн салбарын Энтрепренер
12. Хүнсний салбарын Энтрепренер
13. Тээвэр зуучлал, логистикийн салбарын Энтрепренер
14. Аялал жуулчлалын салбарын Энтрепренер
15. Эрүүл мэндийн салбарын Энтрепренер
16. Усны салбарын Энтрепренер
17. Эрчим хүчний салбарын Энтрепренер
18. Мэдээллийн технологийн салбарын Энтрепренер
19. Үйлчилгээний салбарын Энтрепренер

C. Greenpreneur 2017 номинациуд:

1. Байгальд ээлтэй ногоон технологи нэвтрүүлэгч Энтрепренер
2. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч Энтрепренер
3. Байгалийн нөхөн сэргээгч Энтрепренер
4. Тогтвортой үйлдвэрлэлийн менежмент нэвтрүүлэгч Энтрепренер
5. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Энтрепренер

Шалгаруулалтын материалыг удирдамжийн дагуу бэлтгэн 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 17.00 цаг хүртэл онлайнаар болон хэвлэмэл хэлбэрээр МҮХАҮТ-ын Нэг цэгийн Үйлчилгээний төвд хүлээлгэн өгнө үү.

МҮХАҮТ, Хэрэглэгч Үйлчилгээний газар
Утас: 324394, Гар утас: 88117309, Мэйл: membership@mongolchamber.mn
Вэб сайт: www.mongolchamber.mn

Лавлах

НИЙСЛЭЛ

Хүүхдийн эрхийг хамгаална

Б.Мөнх
ЗГМ

Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулсан хүүхдийн элчийг тодруулах, андгай өргөх ёслол ажиллагаа боллоо. Хүүхдийн эрхийн тухай хуульд заасны дагуу болон бусад холбогдох журмын хүрээнд элчүүд нь хүүхдийн эрх хамгааллын асуудлаар санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зорилготой ажиллах юм. Хүүхдийн элчүүд нь хүүхдийн сайн сайхны төлөө сайн дураар ажиллахаа илэрхийлсэн бөгөөд гурван жилийн хугацаатай ажиллах аж. [ЗГМ]

ФОТО

Уул уурхайн салбар гэрэлт зурагт

"Уул уурхайн салбар 95 жил" ойн арга хэмжээний хүрээнд тус салбарын түүхэн хөгжлийн үйл явцыг харуулсан гэрэл зургийн уралдааныг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Газрын тос, ашигт малтмалын газраас зарлалаа. Хариуцлагатай уул уурхай, Би уурхайчин сэдвийн хүрээнд дээрх уралдааныг зохион байгуулж байгаа бөгөөд ирэх сарын 5-ныг хүртэл бүтээл хүлээн авах юм. Оролцогч номинаци бүрт ганцаарчилсан болон гэрэл зургийн сурвалжилга хэлбэрээр оролцох эрхтэй аж. Монголын уул уурхайн салбарын хувьсал, технологийн дэвшил, уурхайчдын ахуй амьдралын өнгө төрхийг харуулсан гэрэл зургийг олон нийтэд дэлгэн толилуулах юм. Тэрчлэн өнгөрсөн үе, түүхийн жимээр залуу хойч үеэ аялуулах, уул уурхайн салбарын ажил, мэргэжлийн онцлогийг харуулахад уг уралдааны зорилго оршиж байна. [ЗГМ]

УТАА

Эрүүл мэндээ хамгаалах зөвлөмж гаргав

Агаарын бохирдолтой холбоотой өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрүүл мэндээ хамгаалахын тулд иргэд өдөр тутмынхаа амьдралд ямар дадлыг хэвшүүлэх талаар Нийслэлийн эрүүл мэндийн газраас энэхүү зөвлөмжийг гаргав. Үүнд,
-Автозамын хажуугаар гарахдаа хүүхдээ тэвэрч явах
-Амны хаалтыг тогтмол хэрэглэж хэвших
-Биеийн дархлааг дэмжих, цэвэр агаарт салхилах
-Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнүүдийг дэмжих
-Гэрийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах
-Замын хөдөлгөөнд оролцох үедээ цонхоо онгойлгохгүй байх. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	**09:00** "Өглөө" хөтөлбөр	**07:00** "Чарли Роузын ярилцлага" нэвтрүүлэг	**07:05** "Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэлдэйн кино 1.5-10-р анги	**09.30** "Бяцхан эрдэмтэн Сид" 14 дугаар анги
12.00	**11.00** "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр /шууд/	**11:00** "Бизнес аялал" нэвтрүүлэг	**12:10** "Нууц материалууд" ОАК 1.21-р анги	**12:30** "Эрүүл мэндийн өмгөөлөл" ОАК 37 дугаар анги
14.00	**14.30** "Миний нэрийн хуудас"	**14:30** "Амжилтад хязгаар үгүй" нэвтрүүлэг	**14:10** "Та 5 дугаар ангийн хүүхдээс ухаантай юу?" шоу нэвтрүүлэг	**15:30** "Галзуу дурлал" СОАК 11 дүгээр анги
18.00	**18:00** "Эрийн хийморь" Дорнод аймгийн Чойбалсан сумын уяач Б.Бэрхбаяр	**17.00** "Bloomberg Markets: European Open"	**19:00** "Бидний хүүхдүүд" ОАК 21-р анги	**18:30** Наашаа Цаашаа
20.00	**20:00** "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр	**20:30** "Цахиурын хөндийгөөс цааш" нэвтрүүлэг	**21:00** "80 саяын уналт" асуулт хариултын шоу нэвтрүүлэг	**21:00** "Сэжигтэй хамтрагч" СОАК 5 дугаар анги
22.00	**22:10** "Гэмт хэргийн мөрөөр" уран сайхны кино 3, 4-р анги	**22:00** "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	**00:00** Кино миний амьдрал	**00:00** "Чадвал намайг хуур" ОАК 2 дүгээр анги

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Гүн гэрийн гүнж" дахин тайзнаа

Төрийн соёрхолт Ц.Нацагдоржийн "Гүн гэрийн гүнж" дуурь гурван бүлэг, таван үзэгдэлтэй. Тус дуурийг энэ сарын 25-26-нд тоглох гэж байна. Энэхүү дуурь нь анх 2005 онд УДБЭТ-ын тайзны концерт хэлбэрээр тоглогдож байжээ. Уг дуурийн цомнолыг Төрийн шагналт, СГЗ Д.Төрбат бичсэн. Үйл явдал нь манай тооллын өмнөх 50-иад оноос 30-аад онд Хүннү гүрний үед болсон бодит түүхээс үндэслэсэн бөгөөд доктор Л.Эрдэнэчимэгийн "Нүүдэлчний цуурын арван найман аялгуу буюу гүн гэрийн авхай" судалгааны ажлаас сэдэвлэн бүтээжээ. Хан гүрний цэргээс амьд хэл авчрах даалгавраа биелүүлж чадаагүй хоёр цэрэг Цао-Цао жанжны үзэсгэлэнт гүнжийг хулгайлан Хүннү гүрний хаан Жи Жи Шаньюй авчирч өгснөөр үйл явдал өрнөнө. [ЗГМ]

ҮЗВЭР

THE CORPORATE HOTEL & CONVENTION CENTRE

Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Ц.Чулуунбат "BEST OF CHUKA-45" оддын хүндэтгэлийн тоглолтоо энэ сарын 21-нд үзэгч, сонсогчдод өргөн барина. Тэрбээр хэлэхдээ "Монголын орчин үеийн хөгжмийн урлагт 1972 оноос өнөөг хүртэл даруй 45 жил уран бүтээлээ туурвижээ. Энэ хугацаанд бүтээсэн уран бүтээлээ эмхэтгэн хүндэтгэлийн тоглолтоо толилуулах гэж байна" гэв. Тоглолт "The Corporate Hotel & Convention Centre"-т болох бөгөөд тасалбарын үнэ 60, 80, 100 мянган төгрөг.

УДЭТ

Лев Толстойн мэндэлсний 190 жилийн ойг угтаж түүний "Холстомер" бүтээлээс сэдэвлэсэн М.Розовскийн "Адууны түүх" Холстомер хэмээх хоёр бүлэгт жүжгийг энэ сарын 24-нөөс арванхоёрдугаар сарын 3-н хүртэл толилуулна.

УЛААНБААТАР ПАЛАС

"Тусгаар тогтносон Монгол Улс" хэмээн тив дэлхийд тунхаглан зарласан түүхт 93 жилийн ойд зориулсан "Би Монгол хүн" хүндэтгэлийн тоглолт энэ сарын 26-нд "Ub palac"- н концертын их танхимд ганцхан удаа болно. Тоглолтын тасалбар 20 мянган төгрөг.

ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТР

"Жигүүрхэндээ хүчтэй" тоглолт энэ сарын 25,26-нд Хүүхэлдэйн театрт болно. 55 минут үргэлжлэх хүүхдийн жүжгийн тасалбар 5000 төгрөг бөгөөд үндэсний ёс заншил, өв уламжлал, түүний баялаг сангаас суралцах боломж олгоно.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



ХӨНДЛӨНГӨӨР:
1. Хонины хашаа
4. Гэрийн мод
6. Өвс ургамал
9. Монголчуудын эртнээс хэрэглэж байсан гал голомт
12. Шинийн 8-наас урагш, 23-наас хойш тэнгэрт үзэгдэх эрхэс
13. Ирантай удаан хугацаанд дайтсан улс
14. Адууны зүс

ТАШУУГААР:
1. Монгол гэрийн бүрээсний гадуур татах урт оосор
3. Монгол гэрийн хананы гадуур тойруулж татах эсгий, хөвөнтэй халхавч

БОСООГООР:
2. Малаа нүүдэллэн бэлчээрлүүлж таргалуулах арга
4. Юмны ширхэг хэмжээ
5. Хоёр тивийн нутгийг эзлэн орших улс (товчилсон нэр)
6. Хотны үнэнч манаач
7. Үхрийн цөсний чулуу
8. Телевизийн ток шоуны хатан хаан, өв залгамжлагдаагүй тэрбумтан бүсгүй
9. Бүдүүн ширхэгтэй ноос, олсон утсаар нэхэж хийсэн нэг зүйл эд
10. Ардын хувьсгалын анхны долоогийн нэг
11. Ихэнх амин дэмийг агуулсан цагаан идээ

Өмнөх дугаарын хариу / 11.17



ЗГМ: СҮДОКУ

		4		6			3	
9	2	5					4	
		9	4	8				
5			6					
			9				8	7
2			3			5		
4	6				7			2
					2	8		

2	4	1	8	6	5	7	3	9
7	5	9	4	1	3	6	8	2
8	6	3	9	7	2	1	4	5
3	1	6	2	9	7	4	5	8
4	2	5	6	3	8	9	1	7
9	7	8	5	4	1	2	6	3
1	9	7	3	8	6	5	2	4
5	3	4	1	2	9	8	7	6
6	8	2	7	5	4	3	9	1

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	XI.21	XI.22	XI.23	XI.24	XI.25
Өдөр	-13° / 9 м/с	-14° / 7 м/с	-14° / 8 м/с	-15° / 10 м/с	-18° / 11 м/с
Шөнө	-18° / 7 м/с	-21° / 6 м/с	-20° / 6 м/с	-21° / 7 м/с	-23° / 9 м/с
	Бага зэргийн цастай	Багавтар үүлтэй	Бага зэргийн цастай	Бага зэргийн цастай	Багавтар үүлтэй



[ЗГМ СОНИН]
"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.
"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ
99903581, 70103131
УНШИГЧ ТА МАНАЙ СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХҮСЭЛТЭЭ
INFO@ZASAG.CO
ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

ЗУРХАЙ

Билгийн тооллын 3
Өвлийн тэргүүн цагаагчин гахай сарын нэг цагаан мэнгэтэй хар хулгана өдөр.
Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх: 08.11-17.14
Барилдлага: Үхэх
Шүтэн барилдлага: Мунхрахуй
Суудал: Гал

Аргын тооллын арваннэгдүгээр сарын 21. Ангараг гараг. Билгийн тооллын 3. Гар одтой, хар хулгана өдөр.

Өдрийн наран 08.11 цагт мандан, 17.14 цагт жаргана. Тухайн өдөр луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

Эрээн-УБ	18.00	11.15
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Хөх хот	20.00	20.49
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
Замын-Үүд-УБ	21.35	09.55
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Сүхбаатар	10.55	19.52
Сүхбаатар-УБ	06.30	15.35
Зүүнхараа-УБ	04.25	08.40

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	06.10	08.25
Бээжин-УБ	09.30	12.00
Сөүл-УБ	01.25	03.55
Сөүл-УБ	18.15	20.45
УБ-Сөүл	13.00	17.05
Токио-УБ	14.40	19.10
УБ-Токио	07.55	13.40
Ханбумбат-УБ	09.30	12.00
УБ-Ханбумбат	07.30	08.40

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Хятад ДНБ-ээ өсгөхгүй

Хятад улсын эдийн засгийг илэрхийлэгч нь ДНБ-ий өсөлт байж таарахгүй. > 10

Өвлийн олимпийн бэлтгэл сайн ч, тасалбар борлогдохгүй байна

Өмнөд Солонгосын бизнесийн зургаан том групп олимпыг ивээн тэтгэж, тасалбар худалдан авна. > 10

Виртуал тоглоомоор хөлжиж байна

Видео тоглоом Хятадад жилдээ 24 тэрбум ам.долларын орлого оруулж байна. > 10

Брюссель валютын арилжааны луйвартай тэмцлээ

Рошель Топленски

Дэлхийд тэргүүлдэг найман банк гадаад валютын зах зээлд 5.3 тэрбум ам.долларын өртөгтэй картель байгуулж, шударга бус үйл ажиллагаа явуулсан хэргийг мөрдөн байцаах үйл ажиллагаа дөрвөн жил үргэлжилсэн. Европын комисс уг хэргийг эцэслэн шийдэж, санхүүгийн тохиролцоонд хүрэх зорилгоор банкуудтай хэлэлцээ хийхээр төлөвлөжээ. UBS, Royal Bank of Scotland, JPMorgan Chase, Citigroup, Barclays, HSBC болон өөр хоёр банк тохиролцоонд хүрэхийн тулд хэдэн тэрбум евро төлөх байх гэж уг асуудлыг сайн мэдэх эх сурвалж хэлсэн байна. Брюсселийн шийдэж байсан хамгийн томд тооцогдох энэхүү картелийн хэрэг хэд хэдэн валютын оролцоотой буруу үйлдлийг хамарч байгаа тул хөрөнгө оруулагчдын хувьд нэлээд сорилт болно.

Европын комисс уг хэргийг эцэслэн шийдэж, санхүүгийн тохиролцоонд хүрэх зорилгоор банкуудтай хэлэлцээ хийхээр төлөвлөжээ.

BBM©

Түүнчлэн санхүүгийн бенч маркийг буруугаар ашигласан хэргийн олон мөрдөн байцаалтын сүүлийнх нь юм. Өмнө нь Европын холбоо хүүгийн луйвар хийсэн хэрэгт ногдуулж байсан хоёр тэрбум еврогийн торгуулиасч илүү шийтгэл оноох байх гэж ажиглагчид таамаглаж байна. АНУ, Британи, Швейцарт мөрдөн байцаалт явуулж, дэлхийн том банкуудад 10 тэрбум ам.долларын торгууль оноосны дараа Европын холбоо гадаад валютын арилжааны мөрдөн байцаалт хийж байгаа нь энэ юм. Boston Consulting Group-ын тооцоогоор 2008 оноос хойш санхүүгийн байгууллагууд 320 тэрбум ам.долларын торгууль хүлээгээд буй. Нэр дурдсан банкууд ойрын хэдэн сард Европын комисстой хэлэлцээ хийж, тохиролцоонд хүрэхийг эрмэлзэж байгаа аж.

Банкууд тус тусдаа энэ оны эхэнд ЕХ-ны картелийн эсрэг байгууллагатай уулзсан нь үйл явцын эхлэл байв. Дараагийн хэлэлцээ тодорхой авч оны эцэс гэхэд шийдвэр гарах байх гэсэн таамаг байна. Гэвч комисс ба банкуудын аль аль нь тайлбар өгөхөөс татгалзлаа. Албаных "Дэшил гарсан гэхдээ яг шийдсэн зүйл алга" хэмээн хариулсан юм. Картелийн гишүүд эхлээд энэ талаар ЕХ-ны албаныханд мэдээлсэн бол торгуулиас зайлсхийх боломжтой. Хүүгийн түвшинг эхэлж мэдээлсэн байгууллага үлэмж зардлаас зайлсхийсэн жишээ бий. Тухайлбал, Barclays банк еврогийн хүүгээр луйвардсан хэрэгтээ 690 сая евро төлөх шаардлагагүй болсон бол UBS йений хүүн дээр тоглолт хийснийхээ төлөө 2.5 тэрбум еврогийн торгууль төлж магадгүй.



The Wall Street Journal©

Хэлэлцэн тохиролцох замыг сонгосноор банкууд торгуулийн хэмжээг 10 хувиар бууруулах боломжтойгоос гадна хэргийн баримтуудыг илчлэхгүй гэсэн зөвшилцөлд хүрэх ёстой. Эс бөгөөс уг баримтад тулгуурлан хохирлоо төлүүлэх олон зарга үүсэж, шүүхээр шийдүүлэх нөхцөлд хүрч болзошгүй. АНУ-ын зохицуулагчид 2015 онд Barclays, Citi, JPMorgan, RBS, Bank of America, UBS гэсэн зургаан банкийг 2007 оны арванхоёрдугаар сараас 2013 оны нэгдүгээр сарын хооронд гадаад валютын зах зээлд луйвар хийсэн хэрэгт буруутгаж, 5.6 тэрбум ам.долларын торгууль ногдуулсан байдаг.

Торгуулиас гадна банкны ажилтнуудыг хариуцлагад татаж болзошгүй. HSBC банкны гадаад валютын арилжааны захирал асан Марк Жонсоныг АНУ-ын шүүх өнгөрсөн сард үйлчлүүлэгчээ хууран мэхэлсэн хэргээр шийтгэсэн байна. Түүнтэй HSBC-т хамтран ажиллаж байсан Стюарт Скоттыг мөн хэргээр Британиас АНУ-д шилжүүлэн өгөх тухай яригдаж буй. Долдугаар сард валют арилжааны гурван ажилтныг гадаад валютын бенч маркийг буруугаар ашигласан хэрэгт татаад байгаа аж. Barclays, BNP Paribas банкуудын валютын арилжааны ажилтан Жейсон Кац валютын арилжааны зах зээлд үнэ тохиролцох хуйвалдаанд оролцсоныг тогтоосон. АНУ-ын Холбооны нөөцийн банк түүнийг банкны салбарт дахин ажиллахыг хоригложээ.

FT

Чилийн сонгуульд тэрбумтан Пинера тэргүүлэв

Бенедикт Мандер

Баруун төвийн үзэлт, тэрбумтан Себастиан Пинераг Чилийн Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатанд шууд ялах байх гэж таамагласан ч ням гарагт авсан санал нь дийлэнх олонхын дэмжлэг авсангүй ирэх сарын 17-нд болох хоёрдугаар шатны сонгуулиар эцэслэн шийдэх болж байна. Агаарын нислэгийн магнат асан Пинера 2010-2014 оны хооронд Ерөнхийлөгчөөр ажилласан нь 1990-ээд онд генерал Пиночетийн дарангуйлал төгссөнөөс хойш анх удаа барууны улстөрч уг албыг хашсан явдал байв. Энэ сонгуульд саналын 85 хувийг тоолсон дүнгээр тэрбээр 36.7 хувийн дэмжлэг авсан байна. Хоёр дахь шатанд Пинерагийн өрсөлдөгчөөр 22.6 хувийн санал авсан, телевизийн хөтлөгч асан Алехандро Гиллиер тодорчээ.

Ноён Гиллиерийн дараа 20.3 хувийн санал авсан Беатриз Санчез 2011 оны эсэргүүцлийн хөдөлгөөний үеэр нэрд гарч, оюутнуудаас бүрдсэн шинэ нам байгуулсан хүн юм. Ноён Пинера хоёр дахь шатанд бараг ялах нь тодорхой гэж ажиллагчид үзэж байна. Ингэснээр мянган солигдсоноос хойш таваарын өсөлт дээр дөрөөлөн Латин Америкт засгийн эрхэнд гарч байсан зүүний давалгаа саарах эргэлтийн цэг болж магадгүй юм. Ноён Пинера эхний шатанд тэргүүлсэн Чилид бараг 30 жил төрийн эрхийг барьсан зүүн төвийн эвсэл дотор хагарал гаргалаа. Түүнчлэн хэт барууны нэр дэвшигч Хосе Каст найман хувийн санал авч зүүний төвийнхнийг хойш чангаасан байна.

Улс төр судлаач Роберт Функ энэ сонгууль Чилийн нийгэмд гүнзгий туйлшрал үүссэнийг харууллаа хэмээн дүгнэв. Тэрбээр "Хүмүүс шинэ нүүр царайнд саналаа өгсөн ч зөвхөн баруун ба зүүн гэсэн сонголт хийлээ. Төвийн үзэлтнүүд орон зайгаа алдаж буй бололтой. Энэ нь ноён Пинерагийн байдлыг хүндрүүлнэ" гэв. Эвслээс гарсан Христийн ардчилсан намаас нэр дэвшигч Каролина Гойч зургаан хувийн саналаар зургаад бичигджээ. Хэрэв Пинера ялбал аль ч тал нь парламентад олонх болох шинжгүй байгаа тул Христийн ардчилагчид парламентад хүчний тэнцвэрийг тогтооход чухал үүрэгтэй юм.

Ноён Пинера мөрийн хөтөлбөртөө Чилийн эдийн засгийг зогсонги байдлаас гаргах амлалт өгсөн бөгөөд эхлээд таваарын үнэд тулгуурлан өсөлт таван хувьтай байсан үеийг сэргээх бодолтой байна. Зэсийн үнэ сэргэж, бизнесийн итгэл дээшилж байгааг дагаад Чилийн эдийн засгийн өсөлт ирэх жил 3.5 хувьтай байна гэж Moneda хөрөнгийн менежментийн компанийн шинжээчид таамаглажээ. Хатагтай Бачелетийг Ерөнхийлөгч байх үед дээрх хоёр үзүүлэлт унаж, шинэчлэлийн хөтөлбөрийг нь хөрөнгө оруулагчид дэмжээгүй юм. Түүнчлэн 1990 онд Чили улс ардчилалд шилжсэнээс хойш санал өгөгсдийн тоо буурч байгаа нь Пинерад дэмжлэг болсон гэж үзэж байна.

1990 онд Патрисио Аилвин нийт сонгогчдын 47 хувийн саналыг авч Ерөнхийлөгчөөр сонгогдсон бол Бачелет 2013 онд дахин сонгогдохдоо сонгуулийн насны нийт иргэдийн 27 хувийн дэмжлэг авсан түүх бий. Хэрэв ноён Пинера ялбал хатагтай Бачелетийг хоёр дахь удаагаа залгамжлахын зэрэгцээ Аргентиний Ерөнхийлөгч Маурисио Макрийн адилаар амжилттай бизнесмен төрийн дээд тушаалд очиж буй хүн болно. Тэрбээр эхний удаа, 2010 онд хатагтай Бечелетийн халааг авсан бөгөөд тэр үед улс орон нь зогсонги байдалд орж, дотоодын хагаралд автаад байсан билээ.

FT

Өгөгдөл хамгаалах журам зардал өсгөнө

Мехрин Хан

Ирэх оны тавдугаар сараас хэрэгжиж эхлэх Европын холбооны өгөгдөл хамгаалах журам томоохон компаниудын зардлыг хэдэн арван сая доллараар өсгөж болзошгүй байна. Хувийн нууцыг хамгаалах тухай уг журам дэлхийд хамгийн хатууд тооцогддогийг судалгаа харууллаа. Fortune 500 жагсаалтад багтдаг компаниуд Ерөнхий өгөгдлийг хамгаалах зохицуулалтыг зөрчиж Брюсселийн дургүйг хүргэхээс сэргийлэхийн тулд нийт 7.8 тэрбум ам.доллар зарцуулах болсныг Нууц хадгалалтын мэргэжилтнүүдийн олон улсын холбоо тооцоолжээ. Энэ нь компани бүр дунджаар 16 сая ам.доллар зарцуулна гэсэн үг. Уг зохицуулалтын хүрээнд хийгдэх гол өөрчлөлт нь хувь иргэн өөрийн тухай мэдээллээ компанийн серверээс арилгуулах эрхтэй гэсэн заалт юм.

Түүнчлэн аюулгүй байдлын зөрчлийг илрүүлж, тайлагнах шаардлага тусгагджээ. Шинэ журмыг зөрчсөн тохиолдолд бизнесүүд дээд тал нь 20 сая еврогийн торгууль төлөх заалт орсон нь компанийн жилийн орлогын дөрвөн хувьтай тэнцэх агаад хамгийн өндөр торгууль болж байна. Технологийн салбарынхан зохицуулалтад бэлтгэх гэж нэлээд сандарч буй авч Европын иргэдийн хувийн мэдээлэлтэй ажилладаг бүх бизнес журмыг мөрдөх ёстой.

Европын холбоо хувийн нууцын талаар хатуу байр суурь хэдийнээс хэрэгжүүлж эхэлсэн. Facebook мэтийн технологийн авargууд Европын шүүхэд дуудагдаж, Европын хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хуулийн дагуу гаргаж өгөх шаардлагатай тулгараад буй. Нууц хадгалалтын холбооны тэргүүн Тревор Хьюз компаниуд хуульч болон өгөгдөл хамгаалалтын мэргэжилтнүүдийг хөлслөн авч, өгөгдөл боловсруулах орчин үеийн программд хөрөнгө оруулахын сацуу эмх замбараагүй өгөгдлийн сангаа цэгцэлж эхэлснийг онцлов. Тэрбээр "Энэ удаагийн өгөгдөл хамгаалалтын үр дүн дижитал эдийн засгийг ашигладаг иргэд, хэрэглэгчдэд шууд мэдэгдэх болно" хэмээн тайлбарласан юм.

Судалгаанаас үзэхэд санхүүгийн үйлчилгээ ба технологийн салбар хамгийн их зардал гаргах ба дунд зэргийн компани 2018 оны тавдугаар сарын 18 гэхэд журмыг хэрэгжүүлэхийн тулд 550 мянга орчим ам.доллар зарцуулах ёстой. Харин программ боловсруулдаг компаниуд ЕХ-ны журмаас ашиг хүртэх бөгөөд бизнесүүдийн хувийн мэдээллийн санг бүрдүүлэх, хадгалах, боловсруулах ажилд оролцох юм. Microsoft эдгээр туслах компаниудын тоонд багтаж, программ болон үүлэн үйлчилгээг нь ашигладаг бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх аж. Эднийх Европын зохицуулалтад Microsoft нэрийн бүтээгдэхүүнээ нийцүүлэхийн тулд наад зах нь 300 инженер ажиллуулж байгаа юм.

Тус компанийн хэвлэлийн төлөөлөгч "Манай Европын зохицуулалтад нийцүүлэх зардал, ялангуяа үүлэн үйлчилгээний хувьд бусад компаниудын гаргах зардлаас хавьгүй доогуур гарна гэж бодож байна" гэжээ. Тэрбээр мөн "Бид зохицуулалтыг зардал гэхээс илүүтэй бизнесийн боломж гэж харж байна" хэмээн онцлов. Шинжээчид жижиг компаниуд хэрэгжих гэж буй шинэ журмыг сайн ойлгоогүй байх хэмээн болгоомжилж буй. Уг асуудлаар Британийн жижиг компаниудад зөвлөгөө өгдөг TCC фирмийн ажилтан Лорен Моат "Бэлэн болсон буюу тавдугаар сар гэхэд бэлэн болно гэж байгаа компанийг мэдэхгүй байна" хэмээн өгүүлсэн юм.

FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

БНХАУ-ын санхүүгийн бус салбарын өр 2007 онд зургаан тэрбум ам.доллар байсан бол эдүгээ бараг 29 тэрбумд хүрээд байгааг тус улсын дарга Ши Жиньпин Бээжинд үг хэлэхдээ тайлбарлав.

Хятад ДНБ-ээ өсгөхгүй

Майкл Петтис

Өр зээлийн асуудлаа шийдвэрлэхийн тулд эдийн засгийн өсөлт үүсгэх зорилгоосоо татгалзаж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ буурахыг хүлээн зөвшөөрөхөөр Ши Жиньпиний шинэ засаг захиргаа төлөвлөж байна. Шинэ төлөвлөгөө өнгөрсөн сард хуралдсан ХКН-ын XIX Их хурлаар тодорхой болсон юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээ өөрчлөгдөх нь амьдралын стандарт, үйлдвэрлэлийн бүтээмжийн тусгал болдог гэх бодол шинжээчдийн дунд түгээмэл. Гэтэл ийм байр суурь Хятадад тохирдоггүй. Орон нутгийн захиргаад бүтээмж ямар байхаас үл хамааран улсаас тавьсан зорилтот төлөвлөгөөнд нийцүүлэхийг л чармайцгаадаг.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт эдийн засгийн өсөлт хоёр ялгаатай. Ижил хүчин чадалтай хоёр үйлдвэр байна гэж үзье. Эхний үйлдвэр хүмүүст хэрэгтэй бараа, нөгөө нь агуулахад овоорохоос цаашгүй хэрэггүй зүйл үйлдвэрлэдэг. Ийм тохиолдолд ердөө эхнийх нь эдийн засагт өсөлт бий болгож чадна. Харин хоёр үйлдвэр хоёулаа дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг яг адил ихэсгэж байгаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүний статистикийг эдийн засгийн үзүүлэлттэй харгалзуулж байдаг хоёр төрлийн механизм үйлчилдэг. Эхнийх нь төсвийн хатуу хязгаарлалттай бодлого. Зардалд хязгаарлалт тогтоож компаниуд үр ашиггүй бизнест хөрөнгө оруулсаар эцэстээ эдийн засгаа бүрмөсөн гажуудуулах хүртэл ийм бодлого үргэлжилдэг.

Хоёрдугаарх нь, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг зах зээлийн үнийн хүчин зүйлд тулгуурлаж тодорхойлох бодлого. Ийм бодлоготой нөхцөлд үр ашиггүй хөрөнгө оруулалтаас шалтгаалсан чанаргүй зээл багасмагц ДНБ дахь нэмүү өртгийн бүрдэл болон өсөлтийн нийт түвшин буурдаг. Харин БНХАУ-д дээр дурдсан хоёр механизм хоёулаа ажилладаггүй. Чанаргүй зээл багасаагүй. Засгийн газар төсвийн хязгаарлалт тавьсан юм ч алга. Хятад орны мундаг өсөлтийг тодорхойлж буй хөрөнгө оруулалтын оновчгүй хуваарилалт үндсэндээ төрийн салбарт хамаатай.

Ихэнх эдийн засагч хүлээн зөвшөөрөх дургүй ч үр дагавар нь харсаар байтал ил. Найдваргүй зээлийг дутуу үзсэнээс Хятадын ДНБ-ий өсөлтийн статистикт баялгийнх нь бодит өсөлт хэтрүүлсэн үнэлгээтэй. Хятад оронд үр ашиггүй хөрөнгө оруулалт их гэдэгт итгэдэг хүн бүр энэхүү бодит үнэнийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Үүнийг зөв тооцоолох тохиолдолд тус улсын ДНБ-ий өсөлт гурван хувь ч хүрэхгүй хэмээн үздэг эдийн засагчид бий.

Жишээ нь, Японы эдийн засаг 1980-аад онд өнөөгийн Хятадынхтай адил гажуудаж байлаа. Айхтар эрс биш ч Японы дотоодын нийт бүтээгдэхүүн дэх хэрэглээний хувь хэмжээ мөн л ноцтой доогуур орж, хөрөнгө оруулалтад хэт тулгуурласнаас хөрөнгийн хуваарилалт гажуудсан.

Дараа нь, 1990-ээд оны эхээр Япон нь дэлхийн нийт ДНБ-ий 17 хувийг эзэлдэг болох үед тус улсыг эдийн засгаараа дэлхийд тэргүүлнэ гэдэгт эргэлзэх хүн цөөн байсан юм. Гэтэл зээлийн өсөлт тогтворжмогц дэлхийн эдийн засагт Японы эзлэх хувь хэмжээ буурч эхэллээ. Тэр цагаас хойш уг хэмжээ бараг 60 орчим хувиар багасаад байна.

Ийм үзэгдэл хуучин ЗСБНХУ-д ч тохиолдсон. Дэлхийн II дайны дараа эдийн засаг нь асар хурдацтай өсөж, 1960-аад оны эцэс гэхэд дэлхий нийт ДНБ-ий 14 хувийг эзэлдэг болсон нь өнөөгийн Хятадын нөхцөлтэй төстэй байжээ. Зөвлөлт улс удахгүй АНУ-ыг гүйцэж түрүүлэх нь гэсэн бодол тухайн үед хүчтэй байлаа. Уг үеэс хойш 20 жил өнгөрмөгц дэлхийн нийт ДНБ-д ЗСБНХУ-ын эзэлдэг хувь хэмжээ 70 гаруй хувиар унасан юм. Цочирдом эдгээр жишээ өнөөгийн Хятад орныхтой тун төстэй. Урьдын 1980-аад оны Япон, 1960-аад оны ЗХУ аль аль нь ДНБ-дээ үр ашиггүй хөрөнгө оруулалтыг харгалзаж тооцоогүй.

Үр дагавар нь тодорхой. Хятадын өсөлтийн гайхамшиг хэдийнэ шавхарч байна. Тус улс ДНБ-ээ өсгөх зорилтдоо захирагдан өр зээлээ жолоогүй өсөх явдлыг тэвчсээр өдий хүрлээ. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айл өрхийн орлогыг ихэсгэх зэрэг илүү утга учиртай зорилт тавьж буйн шалтгаан чухам үүнд оршино. Тиймээс Хятадын эдийн засгийг илэрхийлэгч нь ДНБ-ий өсөлт байж таарахгүй.

FT

Виртуал тоглоомоор хөлжиж байна

Үхэх сэхэхээ үзэх виртуал тулалдаан бүхий видео тоглоом Хятадад тренд болж байна. Дэлхийн компьютер тоглоомын хамгийн аварга зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэгчид эрх баригчдын зүгээс хориглох эрсдэлийг үл харгалзан мөнгө босгохоор улайрч эхэллээ.

Тоглогчид нь виртуал арал дээр шүхрээр бууж, хамгийн сүүлийн хүн ганцаар тэсэж үлдэх хүртэл үзэлцдэг Battle royal төрлийн тоглоом энэ онд Хятадад сая сая тоглогчдыг байлдан дагуулав. Хятадад хүчирхийлэл сурталчилсан тоглоомыг хориглодог ч маш бодитой зэвсэг хэрэгсэл бүхий ийм тоглоом эрэлт сайтай.

Консалтингийн NewZoo компанийн тооцоогоор видео тоглоом Хятадад жилдээ 24 тэрбум ам.долларын орлого оруулж байна. Хятадын видео тоглоомын зах зээлийн хагасаас илүүг атгадаг интернет конгломерат Tencent компани мөн л тэсэж үлдэх сэдэв бүхий видео тоглоомын мобайл хувилбарыг удахгүй хэрэглэгчдэд хүртээл болгоно. Уг тоглоомын урьдчилсан захиалга хэдийнэ 20 сая даваад байгааг тус компани тайлбарлав. Тоглоомын нэр Glorious Mission буюу "Ялгуусан даалгавар".

"Тэсэж гарах сэдэвтэй тоглоом бол маш чухал ангилал. Энэ жанрт нийцсэн олон төрлийн тоглоом хөгжүүлэх бодол бидэнд бий" хэмээн улирлын санхүүгийн тайландаа өнгөрсөн долоо хоногт нийтэлсэн Tencent-ийн ерөнхийлөгч Мартин Лау тайлбарлав. Зах зээлийн үнэлгээ нь бараг 500 тэрбум ам.долларт хүрэх гэж буй Tencent нь Хятадын хамгийн үнэтэй компани юм.

Тус компанийн видео тоглоомоос олдог орлого сүүлийн улиралд жилийн өмнөхөөс даруй 80 хувь өссөн нь Honour of Kings хэмээн олон тоглогчтой зөгнөлт тоглоомын борлуулалтын ач. Дэлхийд хамгийн ашигтай видео толгоом болж хувираад буй уг тоглоомыг өдөрт 80 сая тоглогч тоглодог.

Энэ сард Honour of Kings-ийн амжилтыг Tencent-ийн гол өрсөлдөгч, Бээжинд байрладаг Netease компанийн мобайл гэйм, Хятадын Apple App Store-аас хамгийн их татагдсан тоглоом эвдэж орхив. Rules of Survival буюу "Тэсэж гарах дүрэм" хэмээх шинэ тоглоомыг татан авагчдын тоо хэт их байснаас компанийн сервер шууд гацжээ.

"Honour of Kings-ийн тоглогчдыг булаах аюул тулгарлаа. Battle royal төрлийн тоглоом ирэх жил ч эрэлттэй байх тооцоог хийсэн Netease компани давуу болж авлаа" хэмээн консалтингийн Pacific Epoch компанийн шинжээч Бенжамин Ву тайлбарлав.

Netease-ийн тоглоом нь PlayerUnknown's Battlegrounds хэмээх Өмнөд Солонгосын компьютер тоглоомтой маш төстэй. Дотоодынхоо хяналтыг давж АНУ-д байрладаг серверүүдээс уг тоглоомыг татаж тоглодог хятадуудын тоо таван саяд хүрчээ.

Нүдэнд илт харагдах цусгүй Netease-ийн тоглоомын виртуал ертөнцөөс Хятадын коммунист намын хэд хэдэн уриа лоозонг олж үзэж болно. Тулаанд орохын өмнө тоглогчоос "Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалж, дэлхийд энх тайван байдал тогтоох" эрмэлзэлтэйг нь асууна.

Уг тоглоом цаашдаа арилжааны хувьд ашигтай байж чадах эсэх нь зохицуулагчдаас хамаарна. Хятадын зохицуулах байгууллага ийм төрлийн тоглоомыг анхааралдаа авч байгаагаа энэ сард мэдэгдлээ. "Зохицуулалт үүсгэчихвэл иймэрхүү тоглоом дорхноо мөхнө. Цензур бол гол шийдвэрлэгч зүйл" хэмээн HIS Markit-ийн шинжээч Цуй Чень-Юи өгүүлж байлаа.

Battle royal тоглоомуудаа "Хятадын уламжлалт болон социалист үнэт зүйл"-д нийцүүлэхээ Netease компани тайлбарласан.

FT

Өвлийн олимпийн бэлтгэл сайн ч, тасалбар борлогдохгүй байна

Брайан Харрис, Кан Бусёон

Өвлийн олимпийн их наадам нь Өмнөд Солонгосын хувьд дэлхийн сонорт хүрэх бас нэгэн чухал арга хэмжээ. Гэвч зарагдаж амжаагүй уул овоо шиг их тасалбар, Умардын зүгээс үйлдэж буй элдэв явуулага ирэх жилийн эхээр болох спортын тоглолтыг өөдрөг төсөөлөхөд хүндрэлтэй болгож байна.

Өмнөд Солонгос нь Сөүлийн 1988 оны зуны олимпийн тоглолтыг дангаараа, 2002 оны Дэлхийн хөл бөмбөгийн цомын тэмцээнийг хамтран амжилттай зохион байгуулсан түүхтэй. Тус улсын удирдлага Пёнчаны 2018 оны тоглолтод ч найдлага тавьж байгаа.

Уг тоглолт нь Өмнөд Солонгосыг өвлийн спортыг улс болгонд харуулах замаар жуулчлалд эрч өгнө хэмээн зохион байгуулагчид нь тайлбарладаг. Хоёр долоо хоног үргэлжлэх спортын арга хэмжээ Өмнөд Солонгост ирэх арван жилд бараг 60 тэрбум ам.долларын ашигтай гэсэн тооцоог Hyundai Research Institute гаргажээ.

Нээлтийн ёслол эхлэхэд гурван сар үлдээд байгаа ч олимпийн уур амьсгал орж өгөхгүй хэвээр. Нийт 1.1 сая ширхэг тасалбарын ердөө гуравны нэг нь борлогдоод байна. Олимпийн уран гулгалтын төрөлд хоёр ч удаа медаль хүртэж, 2014 онд спортыг орхихоосоо өмнө олны хайр татсан од байсан Ким Юна зэрэг дотоодын алдартнууд дутагдаж буй нь өөдрөг бодол өвөрлөхөд саад болов.

Өмнөд Солонгост "үндэсний үзлийн мэдрэмж" алга болжээ хэмээн тус улсын урьд нь зохион байгуулсан спортын хоёр ч мега арга хэмжээнд үндэслэн Кукмин их сургуулийн профессор Ли Дэ-Тек дүгнэв.

"Солонгос тамирчин алтан медаль хүртэх нь улс оронд ач тустай гэж урьдын цагт нийтээрээ үздэг байжээ. Энэ нь Засгийн газар иргэдээ зоригжуулахад түлхэц болсон. Тэр үед спорт олон талын ач тустай гэж бүгд л итгэж байлаа. Гэтэл ач тус нь бага гарлаа. Эдийн засгийн өгөөжийг нь хэт үнэлчихсэн бололтой" хэмээн профессор өгүүлсэн юм.

Пёнчанд шинээр байгуулсан олимпийн стадионд энэ сард "К-Поп" концерт зохион байгуулсан нь амжилтгүй болж, үзэж сонирхсон хэд хэдэн хүн эмчлүүлжээ.

Олимпийн тоглолт нь тус улсын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-д итгэл үл үзүүлэх эсэх улс нийтийг хамарсан дуулиант хэрэгтэй ч бас холбоотой. Хатагтай Пакийг буруутгасан олон хэрэг дотор "удган зөвлөх" Чой Сун Шил олимпийн тоглолттой хамаа бүхий гэрээ хэлэлцээрээс хувьдаа ашиг олдог гэсэн шүүмж багтсан юм.

"Пёнчаны зарим бизнест Чой Сун Шил хутгалдсан нь хүмүүсийн оролцох сонирхлыг бууруулсан"-ыг улс төрийн тайлбарлагч Ли Сеун-Вон өгүүлэв. Гэхдээ алдаатай менежмент, зуны олимпийн арга хэмжээ хоёр ялгаатайг тэрбээр давхар анхааруулав. "Засгийн газар сурталчилгааг үнэндээ оройтуулсан. Өмнөд Солонгосын иргэд өвлийн олимпийн талаар төдий л мэдлэггүй" хэмээн хатагтай Ли тайлбарлав.

Тус улсын олон улсын гол нисэх буудлыг Пёнчан болон спортын уралдаан тэмцээн өрнөх бусад хоттой шууд холбох өндөр хурдны галт тэрэгний шугам зэрэг шинэ дэд бүтэц байгуулах ажил урагшилж байна. Өмнөд Солонгосын Засгийн газар спортын арга хэмжээ болох газруудад үүрэн холбооны 5G сүлжээ туршиж сонирхуулах замаар эх орныхоо технологийн гайхамшгийг ч харуулна. Дэд бүтэц байгуулах ажил одоогоор хуваарийн дагуу өрнөж байна.

"Солонгос гэж юу байдгийг харуулах нэг төрлийн шоу" хэмээн олимпийн тоглолт зохион байгуулах хорооны төлөөлөгч Ли Жи-Хэ өгүүлэв.

Үүний зэрэгцээ пуужингийн довтолгооноос хамгаалах АНУ-ын системийг байршуулах шийдвэрээ Өмнөд Солонгос эргэн харж өөрчилсөн нь Сөүл, Бээжингийн хооронд үүссэн саад тотгорыг арилгаж өглөө. БНХАУ-ын удирдлага гуравдугаас сараас хойш үргэлжилж буй хоригоо зогсоож, жуулчны группүүд нь урьдын адил дорнод хөршдөө зорчиж эхэлнэ хэмээн зохион байгуулагчид найдаж байна.

Тэмцээн дөхөх тусам тасалбарын борлуулалт ихэснэ хэмээн Пёнчаны зохион байгуулах хорооны дэд ерөнхийлөгч Ким Жэ-Ёл тайлбарлав. "Солонгосчууд угаасаа цагийг нь дөхүүлж тасалбар худалдан авдаг. Өмнөх хоёр удаагийн арга хэмжээнд ч тасалбарын ихэнх нь сүүлийн хэдхэн долоо хоногт зарагдсан" хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

Үзэгчийн суудал эзгүй үлдэх аюул нүүрлэх аваас Өмнөд Солонгосын том конгломерат компаниуд худалдан авагч нь болно хэмээн тус улсын иргэд найдаж байна. Тус улсын бизнесийн зургаан том групп ивээн тэтгэж, тасалбар худалдан авахаа пүрэв гарагт мэдэгдсэн.

Харин Умард Солонгосын дарамт арилах шинжгүй хэвээр. Пхеньян есдүгээр сард зургаа дахь удаагаа цөмийн туршилт хийснийх нь дараа болзошгүй аюултай бүсэд тамирчдаа илгээх нь зүйтэй эсэхийг Франц улс эргэцүүлж эхэлсэн. Онцгой нөхцөлд хэрэгжүүлэх нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг Их Британийн баг өнгөрсөн сард танилцуулсан нь байдлыг бүр ч ноцтой болгов.

FT

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Дэлхийн эдийн засгийг 65 тэрбумтан “удирддаг”

Ирэх жилүүдэд хөрөнгө оруулалт ахиж, эдийн засаг хурдацтай өснө

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Олон улсын валютын сан (ОУВС)-гийн тэргүүн Кристин Лагард дэлхийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар байр сууриа илэрхийлснийг хүргэж байна.

Мөнгөний болон сангийн бодлого, бүтцийн шинэчлэлийг хослуулахаас гадна илүү хүчтэй, үр дүнтэй арга санаачлах нь чухал байна.

-Ирэх жилүүдэд Европын эдийн засаг өсөх хандлага мэдрэгдэж буй ч улс төрийн нөхцөл байдал нь тодорхой бус байна. Франц шинэ Ерөнхийлөгчөө сонгоод хоёр сар гаруй боллоо. Мөн АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын Засгийн газар байгуулагдаад хагас жил гаруйн нүүр үзэж буй. Эдгээр үйл явдал Европын эдийн засагт хэрхэн нөлөөлж байна вэ?

-Франц улсын эдийн засгийн байдал евро бүсэд чухал нөлөө үзүүлдэг. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор эдийн засгийн салбарт ямар нэг онц өөрчлөлт ороогүй гэж хэлж болно. Аливаа улсад болсон томоохон үйл явдал тухайн орны эдийн засагт нөлөө үзүүлдэг нь ойлгомжтой. Энэ сард болсон “Их-20”-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр АНУ-ын төрийн нарийн бичгийн даргатай уулзаж, ярилцсан. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон тус улсын Засгийн газар ОУВС-тай хамтран ажиллах сонирхолтой байгааг онцолсон.

-Та гадаад тэнцвэргүй байдлыг бууруулах хэрэгтэй гэж өмнө нь мэдэгдэж байсан. ХБНГУ тэргүүтэй Европын орнууд Евро бүсийн эдийн засгийг өсгөхийн тулд юу хийх хэрэгтэй вэ. Дэд бүтцийн салбартаа хөрөнгө оруулах нь зөв үү?

-ХБНГУ-ын хүн ам нь ерөнхийдөө хөгширч байгаа. Тиймээс ажиллах хүчиндээ анхаарал хандуулах шаардлага гарч байна. Тус улс дэд бүтцийн салбартаа аль хэдийнэ хөрөнгө оруулаад эхэлсэн. Ер нь улс орнууд эдийн засгийн тэнцвэрт байдлаа хадгалах хэрэгтэй.

-АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп ХБНГУ-ын худалдааны илүүдлийг хурцаар шүүмжилсэн удаатай. Үүнд та ямар байр суурьтай байна вэ?

-Санхүүгийн системийн тогтворгүй, тэгш бус байдал эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг. Ноён Доналд Трампын хэлснийг үгүйсгэж болохгүй.

-Дэлхийн эдийн засгийг дунд зэргийн өсөлттэй байна хэмээн тодорхойлж буй. Доналд Трампын санаачилсан эдийн засгийг дэмжих багц бодлого дэлхийн эдийн засагт нөлөөлсөн үү?

-Шинжээчдийн олонх нь эдийн засгийн хүлээлт их байгааг онцолж байна. АНУ татварын бодлогоо шинэчилнэ гэж буй нь эдийн засагт эерэгээр нөлөөлнө гэсэн хүлээлт үүсгээд байгаа. Бидний таамаглаж буйгаар ирэх жилүүдэд дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалт ахиж, хувийн хэвшлийн санхүүжилт өсөж, шилжилт хөдөлгөөн буурч, эдийн засаг хурдацтай нэмэгдэх болно. Улс орнуудад өсөлтөө хэвээр хадгалах боломж бий. Хэдий тийм ч БНХАУ-д өрнөж буй эдийн засгийн шилжилт нь олон улсад тогтворгүй байдал үүсгэж байна.

-Улс орнууд эдийн засгийн өсөлтөө хэрхэн нэмэгдүүлэх вэ?

-Эдийн засгийн бодлогыг үр дүнд хүргэх бүх л боломжийг ашиглах хэрэгтэй. Мөнгөний болон сангийн бодлого, бүтцийн шинэчлэлийг хослуулахаас гадна илүү хүчтэй, үр дүнтэй арга санаачлах нь чухал байна. Төв банкуудын хувьд зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулалгүй, цар хүрээгээ тэлж, бусад эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хэрэгтэй. Ингэж хүчээ нэгтгэн ажиллахыг нэгдсэн, уялдаа холбоо бүхий арга барил гэж нэрлэдэг. Гэхдээ энэхүү арга барилыг зөвхөн нэг улс дангаараа хэрэгжүүлнэ гэж байхгүй.

-Одоогийн эдийн засгийн хямралыг 2008 оныхтой харьцуулбал?

-Энэ бол 2008 оны хямралын үргэлжлэл гэж хэлж болно. Арав орчим жилийн өмнөхтэй ижил хямралын үйл явц бидний нүдний өмнө өрнөж байна.

БНХАУ-ын шилжилт олон улсад тогтворгүй байдал үүсгэж байна

-2008 оны хямралын үед та Францын Сангийн сайд байсан. Тэр үед хямралаас сэргийлэх боломж байгаагүй юу?

-Хямрал болох шинж тэмдэг мэдрэгдэж эхэлсний дараа би АНУ-ын Сангийн сайд Хэнк Полсонтой энэ талаар ярилцаж байсан. Би “Цунами ирэх гэж байхад ямар төрлийн усны хувцас өмсөх вэ гэж яриад сууж байгаагаас өөрцгүй байдалд бид орчихлоо” гэж анхааруулж байлаа. Харин тэр “Үгүй ээ, бүх зүйл хяналтад байгаа. Бүгд хэвийн” гэж хэлж байсныг санаж байна.

-Грек улсад ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2010 оноос хойш 9.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олголоо. Саяхан дахин хоёр тэрбум орчим ам.долларын зээл олгохоор шийдвэрлэсэн. Грект одоо хэрэгжиж буй гурав дахь удаагийн хөтөлбөр ирэх сард дуусна. Цаашид ОУВС-гаас Афинд хөнгөлөлттэй зээл олгох уу?

-Европын бүлэг цаашид ч Афинд тусламж үзүүлнэ. Грек улс одоохондоо хөнгөлөлттэй санхүүжилтгүйгээр, өрийн бүтцийг өөрчлөхгүйгээр эсвэл дефолт зарлахгүйгээр бие даан хөрөнгийн зах зээлд эргэн ирэх боломжгүй байгаа.

-Грект хангалттай тусаллаа. Одоо евро бүсээс хөөх цаг нь болсон гэж үзэж буй хүмүүс ч байна. Таны хувьд энэ хэр зөв санаа вэ?

-Нэгдүгээрт, энэ миний шийдэх асуудал биш. Хоёрдугаарт, евро бүсийн орнууд, Евро комисс, ОУВС Грекийн эдийн засгийг дахин өрсөлдөхүйц хэмжээнд очих хүртэл хамтран ажиллахаа амласан. Дэлхийн 187 орныг эгнээндээ нэгтгэсэн ОУВС-гийн нийт санхүү 842 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна. Энэ мөнгө хямралд нэрвэгдсэн Европын бүх орныг аврахад хүрэлцэхгүй. Гэтэл ОУВС-гийн хамгийн том хандивлагч болох АНУ-д Европыг аврахад мөнгө гаргах сонирхол төдийлэн алга.

-Грек юунаас болоод ийм хүнд байдалд хүрсэн гэж бодож байна вэ?

-Нэгдүгээрт, бүх зүйлийг аль болох эвтэй, уян хатан шийдвэрлэх гээд байх шиг. Энэ нь нэг талаас зөв. Мөн Грекийн улсын төсвийн гуравны нэг, магадгүй дөрөвний нэг нь энэ салбарт зарцуулагдаж байна. Манай дэлхийн хамгийн өндөр тэтгэвэр, тэтгэмжтэй улс гэж болно. Гэхдээ тус улсын тэтгэвэр тэтгэмжийг шүүмжлэх эрх надад байхгүй. Авах ёстой бол авах л байх.

-Дэлхийн цөөн хэдэн баячуудыг эдийн засгийн гол тоглогчид гэдэг. Та үүнтэй санал нийлэх үү?

-Өнөөдөр дэлхийн хэмжээнд голлох үүрэгтэй 62 тэрбумтан бий. Тэд дэлхийн эдийн засгийг чиглүүлж байна гэдэгтэй санал нийлнэ. Баян хүн ч гэсэн бусдад туслах сэтгэлтэй байдаг. Асар их хөрөнгө мөнгөтэй ч хандив, тусламжид хэзээ ч гар татдаггүй тийм эрхмүүдийн талаар би ярьж байна. Тэдний доор ажиллаж байгаа хэдэн зуун сая хүн хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж байгаа нь эргэлзээгүй. Эдгээр тэрбумтнууд манай дэлхийн хүн амын талтай тэнцэх хэмжээний хөрөнгө цуглуулжээ. Хөрөнгө нь жилийн дотор 500 тэрбумаас 1.76 их наяд ам.долларт хүрч, хэдэн арван их наядаар үржиж байна. ОУВС-гийн өнөөгийн үйл ажиллагаа, улс хоорондын мөнгөн тэмдэгтийн гүйлгээ, зохицуулалттай харьцуулахад их тоо.

-Дэлхийн эдийн засаг, санхүүгийн байдал хэзээ сайжрах бол?

-Улс орнуудын эдийн засаг хямарч байгаа нь хэний ч буруу биш. Нэг хэсгийнх нь эдийн засаг уруудаж байхад нөгөө улсынх нь өсөж байдаг. Энэ бол эдийн засгийн бичигдээгүй хууль. Олон улс хоорондын мөнгөн тэмдэгтийн гүйлгээг зохицуулах нь биллийн үүрэг. Гэхдээ гол үүргийг улс орнуудын мөнгөн тэмдэгт л гүйцэтгэдэг. Миний харж байгаагаар, дэлхийн эдийн засаг цаашид улам өсөхөөр байна. Ер нь дэлхийн эдийн засаг болж эхэлж байна гэхэд буруудахгүй. Улс орнууд өөрсдийн мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ, ханшийг барих гэж зовж зүдэрч байхад нөгөө хэсэг нь улам баян болж байна. Гол ялгаа энд л бий.

-Мөнгөн тэмдэгтийн ханшид үйлчилж, нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл юу вэ. Үүнд алтыг нэрлэж болох уу?

-Дээр үед алт, дунд үед газрын тос байсан. Харин өнөөдөр гол “тоглогч” нь экологийн ашигтай байрлал, байгалийн баялгийн нөөц болж хувирч байх шиг.

-ОУВС энэ жил ямар ажил төлөвлөж байгаа вэ?

-Манай сангийн хөрөнгө оруулагчид, дэмжигчид санхүүжилтийн эх үүсвэрүүдийн асуудлаар жил бүрийн хоёрдугаар сард хуралддаг. Үүнийг улс орнуудын валютын ээлжит хуралдаан гэж ойлгож болно. Энэ хурлаар бид жилийн төлөвлөгөөгөө танилцуулдаг. Мөн валют хоорондын ялгаа, мөнгөний тэнцвэрт байдлыг харуулсан илтгэлүүдийг хэлэлцдэг. Сангийн үйл ажиллагаа гэхээс илүүтэй хөрөнгө татах, валют хоорондын тэнцвэрийг тогтоох аргачлал зэргийг ярилцдаг юм. Мөн улс орнуудын хямралтай байдлыг засах, санхүүгийн болон өр зээлийн асуудлыг цэгцлэх бодлогын хүрээнд тодорхой алхмуудыг хийхээр төлөвлөсөн. Энэ нь тун энгийн.

Эхлээд зээл авлагыг тэглэх, хүү бодох, дахин зээл гаргах боломжтой эсэхийг судлах зэрэг шат дараалсан ажил биднийг хүлээж байна. Ирэх оны хавар бид ОХУ-ын рублийн ханшийн талаар бага хурал хийхээр төлөвлөсөн. Уг хурлаар олон улсын зүгээс ОХУ-ын эсрэг тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээ нь рублийн ханшид хэрхэн сөргөөр нөлөөлж, бүс нутгийн валютын тэнцвэрийг алдагдуулж буйг хэлэлцэх юм. [ЗГМ]

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

“Fitch” Монголын зээлжих зэрэглэлийн төлөвийг “эерэг” болгов

Э.Эрдэнэтуяа
Шинжээч



Олон улсын үнэлгээний “Fitch” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг “тогтвортой”-оос “эерэг” болгон ахиуллаа. Харин ерөнхий зэрэглэлийг өөрчлөлгүй “B-“ зэрэглэлд хэвээр үлдээсэн байна. Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжсэнээр ирэх жилүүдэд 3.5 тэрбум ам.долларын санхүүжилт орж ирэх боломж бүрдсэн юм. Үр дүнд нь хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, 800 сая ам.долларын бонд гаргахад түлхэц болсон гэж “Fitch” агентлаг үзсэн байна. Нэмэлт санхүүжилтийг дагаад санхүү, эдийн засгийн төлөв ч мөн сайжирсныг тус агентлагийн шинжээчид онцолжээ. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлын хэмжээ энэ онд 7.3 хувьтай гарч, ирэх онд 6.5 хувь болж буурахаар байна. Мөн 2018 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 4.5 хувиар өсөх төлөвтэй байгааг “Fitch” агентлаг таамаглаж байна. Өмнө нь тус агентлаг шинээр гаргасан Монгол Улсын Засгийн газрын бондод улсын зээлжих зэрэглэлтэй ижил “B-“ үнэлгээг өгсөн юм. Өнөөгийн ханшаар нэгж бондын үнэлгээ 100.2 ам.долларт хүрч, өнгөрсөн даваа гарагийн түвшнээс 60 центээр өсөөд байна.

СТАТИСТИК

Нийслэлийн инфляц өсөв

Улаанбаатар хотын инфляц аравдугаар сард өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 11 хувиар, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 7.5 хувиар өссөн байна. Түүнчлэн аравдугаар сард өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн юм. “Цаашид үнийн өсөлт болгоомжлох асуудал мөн” гэдэгт эдийн засагчид санал нэгтэй байна. Үнийн өсөлтийг бүлгээр нь задалбал тээврийн бүлгийн үнэ 10.7 хувиар өсчээ.

Үүнийг уул уурхайн идэвхжилтэй холбон тайлбарлаж байгаа юм. Тухайлбал, нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үеэс гурав дахин өссөн байна. Түүнчлэн хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 8.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд ялангуяа төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 26.5 хувиар нэмэгджээ. Энэ жил ургац хураалт тааруухан байгаа бөгөөд үр тарианы ургацын 50 хувийг алдсан талаар Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамнаас мэдээллээ.

ЗГМ ТОВЧХОН

» БАНК, САНХҮҮ

291

Хадгаламж, зээлийн хоршоо. Энэ оны гуравдугаар улиралд улсын хэмжээнд нийт хадгаламж, зээлийн 291 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Ирэх сарын 31 хүртэлх хугацаанд 19 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болно гэж Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээллээ.

» ФОРУМ

Олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд БНСУ-ын Сөүл хотноо чуулж байна. Энэхүү чуулга уулзалтаар финтек буюу мэдээллийн технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ, түүний бодлого, зохицуулалтын талаар ярилцлаа.

» АЛТ ТУШААЛТ

20

Тонн алт. Монголбанк энэ оны эцэст алт худалдан авалтынхаа хэмжээг 20 тоннд хүргэхээр зорьж байна. Төв банк энэ сарын байдлаар 18.4 тонн алт худалдан авснаар өнгөрсөн онд үзүүлсэн түүхэн дээд хэмжээ болох 18.3 тонныг давлаа.

» МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

1.5

Хувь. Мөнгөний нийлүүлэлт 1.5 хувиар буурч, 14.5 их наяд төгрөг болов. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн хэвээр байна.

» АРИЛЖАА

420

Тэрбум төгрөг. Хөдөө аж ахуйн бирж энэ оны эхний арван сарын байдлаар 420 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ.

» ХӨРШ

30

Хувь. БНХАУ-ын интернет үйлчилгээний “Baidu” компани “China Citic” банктай хамтран “Aibank” нэртэй банкны шинэ үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ. “Baidu” компани хоёр тэрбум юанийн хөрөнгөтэй шинэ хамтарсан компанийн 30 орчим хувийг эзэмшихээр болов.

» ДЭЛХИЙ

40

Тэрбум ам.доллар. Германы автомашин үйлдвэрлэгч “Volkswagen” компани ирэх таван жилийн хугацаанд автомат жолоодлоготой болон цахилгаан автомашины үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 40 тэрбум ам.доллар зарцуулна гэдгээ мэдэгдлээ.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2,444.66
Евро	2,874.38
Япон иен	21.83
ОХУ рубль	41.21
БНХАУ юань	368.69
БНСУ вон	2.23

Эдийн засаг

ТЕХНОЛОГИ

Хиймэл оюун ухаан дэлхийн өсөлтийг дэмжинэ

Г.Байгал
@baigalZGM

Хиймэл оюун ухаан хаянд ирлээ

Бидний хол хэмээн тооцож байсан ирээдүй хэдийнэ дэргэд ирчихсэн, хаалга тогшиж байна. Өмнө нь зөгнөлт кино, зохиолын номноос л уншиж, гайхдаг байсан хиймэл оюун өдгөө нийгмийн амьдралд нэвтэрч эхэллээ. Ийн хүн төрөлхтний амьдралд уусан, шингээд зогсохгүй нийгмийн нэгж, хэсэг, шат давхарга бүрт хувьсал, өөрчлөлт дагуулж байна. Тэгвэл хиймэл оюун дагасан хувьсал бизнесийн орчинд хэрхэн нөлөөлөх бол. Accenture and Frontier Economics-ийн тооцоогоор хиймэл оюун ухаан нь бүтээмжийг өсгөж, зардал хэмнэн, эдийн засагт ээлээ харамгүй үзүүлнэ. Гэхдээ амаргүй сорилтыг цөөнгүй асуултын хамт давхар авчрахаар байгаа нь яавч анхаарлын гадна үлдээж боломгүй сэдэв болчихоод байна.

ӨСӨЛТИЙГ ӨДӨӨГЧ

Юуны түрүүнд программ хангамжид суурилсан энэ төрлийн ухаан дэлхийн өсөлтийг дэмжинэ. Хиймэл оюун ухаан хүрээгээ тэлснээр дэлхийн дийлэнх орны ДНБ-ий өсөлт хоёр дахин хурдасна гэж Accenture and Frontier Economics-ээс танилцууллаа. Тухайлбал, цэнхэр гарагийн тэргүүлэх эдийн засаг болох АНУ-ын ДНБ 2035 онд бие даан 2.6 хувиар өснө. Харин хиймэл оюун ухаан хүч нэмснээр тус улсын ДНБ-ий өсөлт бараг хоёр дахин хурдасч, 4.6 хувьд хүрэх төлөвтэй байна. Тэгвэл нүдэнд үзэгдэж, гарт баригдахгүй энэ зүйл хэрхэн өсөлтийг бүтээх вэ. Шинжээчдийн тооцоогоор бизнес эрхлэгчид хиймэл оюун ухаан ашигласнаар хөдөлмөрийн бүтээмж нь дунджаар 40 хувиар нэмэгдэж, энэ нь эргээд ДНБ-ий өсөлтийг өдөөх аж. Өдгөө тээвэр болон автомашины салбарт хамгийн түгээмэл ашиглаж буй хиймэл оюун ухааны зах зээл 2020 он гэхэд 5.05 тэрбум ам.доллараар хэмжигдэхээр байна.

- **Хиймэл оюун ухаан хүрээгээ тэлснээр дэлхийн дийлэнх орны ДНБ-ий өсөлт хоёр дахин хурдсах тооцоог Accenture and Frontier Economics-ээс танилцууллаа.**
- **Тэд худалдан авагчдад тусалж, бараа бүтээгдэхүүний мэдээлэл хүргэхийн зэрэгцээ, хамгийн тохиромжтой сонголт хийхэд нь тусалдаг аж.**
- **Хиймэл ухааны ачаар хорт хавдрын эсрэг эм бүтээх хугацаа, хөрөнгө оруулалт хоёр дахин багасна.**

ЭНХИЙН МАНААНД

Эрүүл мэндийн салбарт шинэ оюуны гүйцэтгэх үүрэг улам гүнзгийрч байна. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи нь эмчилгээний үр дүнг дээшлүүлж, оношилгоог сайжруулж, эмийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж буй. Тухайлбал, хорт хавдрын эсрэг эм бүтээх хугацаа, хөрөнгө оруулалт хоёр дахин багасна. Өдгөө энэ төрлийн эм бүтээхэд 12-14 жил, 2.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаарддаг. Харин хиймэл оюун ухааны тусламжтай эдгээр үзүүлэлт хоёр дахин багасаж, хавдрын эсрэг шинэ эмийг долоон жилийн дотор зах зээлд нийлүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарчээ. Гэхдээ уг эмийн хүртээмж, үр дүн улам нэмэгдэх аж. Тухайлбал, нэг эмийг дунджаар 10 мянган хүн хэрэглэдэг бол ирээдүйд энэ тоо 10 саяд хүрэхээр байна.

Дэлхий даяар зам, тээврийн ослоор жилд дунджаар 1.25 сая хүн амиа алдаж, зам, тээврийн ослоос үүдэн 518 тэрбум ам.долларын хохирол учирдаг гэсэн тооцоо бий. Энэ байдлаар үргэлжилбэл зам, тээврийн осол 2030 он гэхэд хүн төрөлхтний үхлийн таван том шалтгааны нэг болох магадлалтай. Тэгвэл үүнийг бууруулахад хиймэл оюун ухаан тустай. Учир нь хиймэл оюун ухаан нь сэтгэл хөдлөл, ядаргаа зэрэг жолоочид сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлээс ангид тул сөрөг бус илүү эерэгээр нөлөөлнө гэж таамаглаж байна.

Ажилгүйдэл нь роботуудын авчирч буй асуултын тэмдэг

Зөвхөн зорчигчоор зогсохгүй ачаа тээвэрт ч чухал нөлөөтэй. Ачааны автомат жолоодлоготой машины туршилт үргэлжилж байна. Энэ төрлийн авто машин үйлдвэрлэгч Otto компани тээврийн хэрэгслээ хойд Калифорнид туршиж байгаа бөгөөд одоогоор зөвхөн хурдны замыг ашиглаж буй. Харин 2020 он гэхэд хурдны замаас хальж бусад автозамаар тээвэр хийх боломжтой аж. Ачаа тээврийн зардлын гуравны нэгийг жолооч нарын нөхөн олговорт зарцуулдаг. Харин энэ чиглэлд хиймэл оюун ухаан нэвтэрснээр ийм зардлууд буурна гэж үзэж буй.

ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА

Жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд энэ төрлийн роботуудыг туслах ажилтнаар ашиглаж буй. Тэд худалдан авагчдад тусалж, бараа бүтээгдэхүүний мэдээлэл хүргэхийн зэрэгцээ, хамгийн тохиромжтой сонголт хийхэд нь тусалдаг аж. Япон улсад Nescafe компанид Nespresso кофены машин сонгоход нь туслахын тулд 1000 роботыг жижиглэнгийн дэлгүүрүүдэд байрлуулжээ. Түүнчлэн Японы Telco SoftBank 19 хэлээр ярьдаг, нүүрний хувирал, харилцаанаас худалдан авагчийн зан төлөвийг тандан мэддэг роботыг борлуулалтын ажилтнаар ажиллуулж байна.

АЖЛЫН БАЙРАНД АЮУЛЫН ХАРАНГА

Хиймэл оюун ухаантай роботууд ийнхүү хөдөлмөрийн зах зээлд нэвтэрч эхэлснээр зарим ажилтан шахагдах болов. "Bloomberg" болон Оксфордын их сургуулиас ойрын хугацаанд хиймэл оюун ухаанаар орлуулах боломжтой 700 гаруй ажлын байрны жагсаалт гаргасан. Тэгвэл энэ жагсаалт өдгөө дахин шнэчлэгдэж, улам уртсах төлөвтэй байна. Хиймэл оюун ухаанд хамгийн түрүүнд ажлын байраа алдах мэргэжлийн тоонд зээлийн эдийн засагч, ресепшин, түргэн хоолны газрын тогооч, хамгаалалтын ажилтнууд, таксины жолооч жагсаж буй. Мөн хөгжмийн мэргэжилтэн, эвлүүлэгчдийг ийм ирээдүй хүлээж буй аж.

Тэр бүү хэл, харьцангуй нарийн гэгддэг хуулийн мэргэжлийг ч хиймэл оюун ухаан тойрсонгүй. Тодруулбал, хууль зүйн Baker-Hostetler фирм РОСС нэртэй, өмгөөлөгч робот ажиллуулж эхэлсэн бөгөөд магадлал дэвшүүлж, мэдээлэл цуглуулах, шүүх хуралд хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэдэг байна. Ингэснээр мэргэжлийн өмгөөлөгчдөд тусламж үзүүлж байгаа аж. Тэрчлэн 2020 онд Японд болох Олимпийн наадамд оролцох гадаадын жуулчдад туслах роботуудыг одооноос туршиж байна.

Ийнхүү хиймэл оюун ухаан нь сайныг дагуулах бол саарыг ч мөн авчрах нь. Ялангуяа, ажилгүйдэл нь роботын авчирч буй асуултын тэмдэг. Хиймэл оюун ухаантнууд хөдөлмөрийн зах зээлд хүч түрч, энэ хэрээр хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хумигдах нь ойлгомжтой болоод байна. Ингэснээр хүн төрөлхтний нийгэмд гүйцэтгэх шинэ үүргийн эрэлд гарах шаардлага тулгарах нь. Цаашлаад хиймэл оюун ухаан хүмүүсийн зан заншилд хэрхэн нөлөөлөх, технологид саатал гарлаа гэхэд хүмүүс өөрсдийгөө хэрхэн хамгаалах, роботуудад хэрхэн хяналт тавих зэрэг олон асуулт өнөө хэр хариулт нэхсээр. Шийдэл нэхсэн эдгээр асуултаас бултах аргагүй тул хэдийнэ хаянд ирсэн хиймэл оюун ухаантай холбоотой асуудлыг цэгцлэх, нэг тийш нь шийдэх цаг тулгарч байна. [ЗГМ]

Алтны ханш тогтвортой байна



Хөрөнгө оруулалтын эрсдэлгүй хэрэгслийн нэгд тооцогддог алтны ханш олон улсын зах зээлд тогтвортой байна. Даваа гарагт унци алтны ханш 1291 ам.долларт хэлбэлзэж байгаа нь хоёр долоо хоногийн дээд цэг болов. Аравдугаар сарын дунд үеэс суларч эхэлсэн уг металлын үнэ өнгөрсөн долоо хоногийн сүүлчээс өсөж эхэлсэн юм. Алтны ханштай зэрэгцээд ам.долларын ханш хэлбэлзэж байна. Bloomberg-ээс тооцдог ам.долларын спот ханш 0.7 хувиар буурсан ч эргээд 0.3 хувиар өслөө. Европтой харьцах ам.долларын ханш гэхэд 0.5 хувиар чангарсан байна. Үүнтэй зэрэгцээд цахим валют болох биткойны ханш ч чангарч байна. Тус мөнгөн тэмдэгтийн ханш дөрвөн хувиар өссөнөөр 8000 ам.долларыг давaад байна. [ЗГМ]



МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	70.8	▼ -0.13%	11/20/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.019	▼ -5%	11/20/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	6.5	▼ -3.70%	11/20/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.015	▲ 7.14%	11/20/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	11/20/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.7	▼ -2.49%	11/20/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.91	▲ 2.36%	11/20/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.2	▲ 14.29%	11/20/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.62	▼ -6.06%	11/20/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.27	▼ -3.57%	11/20/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ ($)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1291.41	▼ -0.08%	11/20/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	945.6	▼ -0.94%	11/20/2017
МӨНГӨ	SIA	унци	17.18	▼ -1.11%	11/20/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	308.45	▼ -0.21%	11/20/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	61.49	▼ -0.18%	11/20/2017
WTI ТОС	CLA	баррель	56.46	▼ -0.16%	11/20/2017
БРЕНТ	COA	баррель	62.37	▼ -0.56%	11/20/2017
БЕНЗИН	XBA		173.51	▼ -0.55%	11/20/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.04	▼ -1.84%	11/20/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ 0.21%	11/20/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	89.95	▼ -1.48%	11/20/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.149	▼ -2.67%	11/20/2017
БУДАА	RRA	центнер	12.28	▼ -0.04%	11/20/2017
БУУДАЙ	WA	бушель	440	▼ -0.79%	11/20/2017
КАКАО	CCA	тонн	2108	▼ -1.08%	11/20/2017
КОФЕ	KCA	фунт	1.268	▼ -0.31%	11/20/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)		ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	792.76	▼	-0.78%	11/20/2017
ГОВЬ ХК	GOV	25060	▲	4.59%	11/20/2017
МАХ ИМПЕКС ХК	MMX	2750	▼	-0.11%	11/20/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	599.97	▲	0.82%	11/20/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	22000	▼	-1.26%	11/20/2017
СҮҮ ХК	SUU	225.53	▲	0.38%	11/20/2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	9410	▲	0.21%	11/20/2017
БАГАНУУР ХК	BAN	2500	▼	-1.61%	11/20/2017
БИ ДИ СЕК ХК	BDS	1210	▲	0.75%	11/20/2017
АРИГ ГАЛ ХК	EER	4150	▲	9.21%	11/20/2017
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	ETR	75.1	▼	-6.13%	11/20/2017
ГУТАЛ ХК	GTL	22500	▲	13.07%	11/20/2017
ХӨХ ГАН ХК	HGN	75	◀▶	0%	11/20/2017
АЙТҮҮЛС ХК	ITLS	152.08	▲	14.99%	11/20/2017
ЖЕНКО ТУР БЮРА ХК	JTB	62.01	▲	0.02%	11/20/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	540.6	▼	-5.84%	11/20/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6782.791	-10.5	▼ -0.15%	11/20/2017
DAX INDEX	DAX	13019.46	+25.73	▲ +0.2%	11/20/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15998.57	+63.2	▲ +0.4%	11/20/2017
S&P/ASX 200	AS51	5945.671	-11.58	▼ -0.19%	11/20/2017
S&P 500	INX	2578.85	-6.79	▼ -0.26%	11/20/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3392.399	+9.49	▲ +0.28%	11/20/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	23358.24	-100.12	▼ -0.43%	11/20/2017
TOP 20	MSETOP	21764.14	+288.75	▲ +1.34%	11/20/2017
FTSE 100	UKX	7373.2	-7.48	▼ -0.1%	11/20/2017
HANG SENG	HSI	29260.31	+61.27	▲ +0.21%	11/20/2017
NIKKEI 225	NKY	22261.76	-135.04	▼ -0.6%	11/20/2017